



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт үр нөлөө багатай, үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих шат шатны хяналт сул, үр ашиг хангалтгүй байна.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

Улаанбаатар хот
2022 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/15

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын (НАГ-2022/22-11-ШТА-ГА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2023 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумъяабазар), Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа), Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 2 дугаар улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэл, дүүргийн Засаг дарга, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010055

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	4
Аудитын III хэлтэс	Хавсралтын жагсаалт	4
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Хэлтсийн дарга, аудитын менежер:	Бүлэг 1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй байна уу?	7
Э.Мөнхмандах	1.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн үү?	7-12
Аудитын менежер:	Л.Саранбаатар	
Ахлах аудитор:	Б.Билэгт	12-17
Аудитор:	Ч.Чулуун-Эрдэнэ	
	О.Оргил	18
	О.Дашхонгор	
	Б.Ууганбилэг	18-22
Гэрээт ажилтан:	П.Энхбаяр	
	2.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, баталсан уу?	22-26
	2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн үү?	26-33
	2.3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангаж, үр ашигтай байна уу?	33-39
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө “Г” корпус, Утас: 327787	2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж байна уу?	40
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Бүлэг 3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй байна уу?	40-42
	3.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна уу?	42-45
	3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна уу?	45-48
	3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна уу?	
	Аудитын дүгнэлт	49
	Аудитын зөвлөмж	50-51
	Хавсралтууд	52-60

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ДИТХ	Дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ДЗТГ	Дүүргийн засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол Улс
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
УЗ	Удирдах зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Орон нутгийн өмчийн оролцоотой газрууд	6
Хүснэгт 2	2019-2021 оны зорилтот түвшин, гүйцэтгэл	19
Хүснэгт 3	2020 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт	20
Хүснэгт 4	2021 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт	21
Хүснэгт 5	Эдийн засгийн зорилтот түвшний хянасан байдал	21
Хүснэгт 6	Орлого төвлөрүүлэлт	22-23
Хүснэгт 7	Орлого төвлөрүүлэлт	23
Хүснэгт 8	Авлагын судалгаа	24
Хүснэгт 9	Татвар, төлбөр, хураамжийн ноогдол гүйцэтгэл	25
Хүснэгт 10	Татвар, төлбөр, хураамжийн үлдэгдэлтэй газрууд	25
Хүснэгт 11	Эргэлтийн харьцаа	26
Хүснэгт 12	Түргэн хөрвөх чадвар	27
Хүснэгт 13	Борлуулалтын өгөөж	27
Хүснэгт 14	Хөрөнгийн өгөөж	27-28
Хүснэгт 15	Цэвэр активын өгөөж	28
Хүснэгт 16	Өрийн харьцаа	28
Хүснэгт 17	Өр төлбөр ба ЭӨ-ийн харьцаа	28
Хүснэгт 18	Дансны авлагын эргэц	28-29
Хүснэгт 19	Өрийн харьцаа	29
Хүснэгт 20	Бие даах чадварын коэффициент	29
Хүснэгт 21	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	29
Хүснэгт 22	Алдагдлын талаар	29
Хүснэгт 23	Нийслэлийн өмчит ХХК, ХК-ийн орлого, зардал, ашиг/алдагдал	31
Хүснэгт 24	ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийн зардлын үзүүлэлт	34
Хүснэгт 25	Нийслэлийн ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны зардлын үзүүлэлт	34
Хүснэгт 26	Нийслэлийн өмчит ААТҮГ-ын 2019-2021 оны ашиг, алдагдал	35-36
Хүснэгт 27	2019-2021 оны зорилтот түвшин, гүйцэтгэл	37
Хүснэгт 28	НТАГ-аас хийсэн санхүүгийн аудитаар өгсөн үүргийн биелэлт	38-39
Хүснэгт 29	ТБОНӨҮГ-уудын мэдээлсэн тоо	42
Хүснэгт 30	ТБОНӨ-ийн оролцоотой компаниудын мэдээлсэн тоо	47

Графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
График 1	Авлагын дүн	25
График 2	Нийт хөрөнгөд эзлэх санхүүгийн үзүүлэлт	30
График 3	Орлогын тайлангийн шинжилгээ	30
График 4	Урсгал зардлын задаргаа	31

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	52
Хавсралт 2	Дүүргийн ЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	52-53
Хавсралт 3	НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	53-54
Хавсралт 4	Дүүргийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	54-56
Хавсралт 5	ТБОНӨ хуулийн этгээдүүдийн ТУЗ, УЗ-тай эсэх мэдээлэл	56-57
Хавсралт 6	Санхүүгийн тайлангийн балансын шинжилгээ	57
Хавсралт 7	Орлогын тайлангийн шинжилгээ	57-58
Хавсралт 8	Аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газрын орлого, зардлын дүн	58-59
Хавсралт 9	Цахим хуудсаар мэдээллийн ил тод байдлыг хангасан байгууллагууд	59
Хавсралт 10	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2019-2020 онд шилэн дансанд мэдээлсэн байдал	60

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: ○ Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх; ○ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх; ○ Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Нийслэл, дүүргийн орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд болон холбогдох бусад газруудыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг 3 дугаар хэлтсийн дарга Э.Мөнхмандах удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Билэгт, аудитор Ч.Чулуун-Эрдэнэ, О.Дашхонгор, О. Оргил, Б.Ууганбилэг, гэрээт ажилтан П.Энхбаяр нар гүйцэтгэв. Аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	Аудитын талбарын ажлыг 1 сарын хугацаанд гүйцэтгэсэн нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал, шалгагдагч байгууллагаас баримт материал гаргаж өгөхгүй байх, судалгаа мэдээг дутуу, буруу гаргах зэрэг хүндрэл бэрхшээл үүсэж байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 98 хуулийн этгээд байна.

Хүснэгт 1. Орон нутгийн өмчийн оролцоотой газрууд

№	Нэр	ОНӨААТҮГ	ОНӨТҮГ	ХК	ХХК	Нийт /тоо/
1	НЗД	18	13	5	4	40
2	БГД ЗД	7	2			9
3	БЗД ЗД	9	1			10
4	СХД ЗД	6				6
5	СБД ЗД	2	1			3
6	ХУД ЗД	9	1			10
7	ЧД ЗД		3			3
8	БНД ЗД	2	5			7
9	НД ЗД	6	1			7
10	БХД ЗД	2	1			3
Нийт		61	28	5	4	98

Судалгаагаар эдгээр хуулийн этгээдүүд 611.9 тэрбум төгрөгийн орлого, 765.0 тэрбум төгрөгийн зардал, 118.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардлын 765.0 тэрбум төгрөгийн зардлын 109.3 тэрбум төгрөг буюу 14.3%-ийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 89.6 тэрбум төгрөг буюу 11.7%-ийг Ус сувгийн удирдах газар, 39.4 тэрбум төгрөг буюу 5.1%-ийг Зорчигч тээврийн нэгтгэл, 24.7 тэрбум төгрөг буюу 3.2%-ийг Зорчигч тээвэр гурав, 65.6%-ийг бусад аж ахуйн нэгж эзэлж байна.

Хүлээж буй нийт 118.6 тэрбум төгрөгийн алдагдлын 23.3 тэрбум төгрөг буюу 19.6%-ийг Ус сувгийн удирдах газар, 12.7 тэрбум төгрөг буюу 10.7%-ийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 5.1 тэрбум төгрөг буюу 4.3%-ийг Зорчигч тээврийн нэгтгэл зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

УБ хотын нийтийн үйлчилгээ, иргэдийн эрх, ашиг, аюулгүй байдлыг хангахад төрөөс зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, эзэмшиж буй хөрөнгийн насжилт өндөр, хөрөнгийн шинэчлэлтийг тухай бүр хийж чаддаггүйгээс элэгдлийн зардал нь өссөн зэрэгтэй холбоотой байна.

Харин бусад 12 ААТҮГ нь 2019-2021 онд нийт 18.8 тэрбум төгрөгийн алдалдалтай ажилласан нь нийт алдагдлын 15.6%-ийг эзэлж байгаа бөгөөд эдгээр үйлдвэрийн газруудын хэрэгжүүлж буй чиг үүргүүдийг хувийн хэвшлийн компаниудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэх боломжтой байна.

Эдгээрийн 61 нь ОНӨААТҮГ, 28 нь ОНӨТҮГ, 5 нь ХК, 4 нь ХХК байна.

Аудитын түүвэрт орон нутгийн өмчит ХХК 2, ХК 2, ОНӨААТҮГ 23, ОНӨТҮГ 1, төрийн өмчит 2 ХК, нийт 30 газрыг хамруулсан.

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Өмнөх жилүүдэд гүйцэтгэлийн аудитад хамрагдсан газруудыг түүвэрлэлтээс хассан болно.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

1.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн үү?

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Компанийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2016 оны 45 дугаар тогтоолоор МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, НИТХ-ын 2016 оны 3/08 тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2020 оны 02/10 тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, СЗХ-ны 2007 оны 210 дугаар тогтоолоор “Монголын компанийн засаглалын кодекс”, МУ-ын ЗГ-ын 2011 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, СЗХ-ны 2014 оны 162 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ыг тус тус баталсан. СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолоор кодексийг шинэчлэн баталсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч зохицуулалт хангалтгүй, хуультай нийцүүлэн гарах зарим дүрэм, журам нийслэл, орон нутагт харилцан адилгүй мөрдөгдөж байгаагаас компанийн үйл ажиллагаа зохистой түвшинд хэрэгжихгүй байна.

1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

УИХ-аас Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль тогтоомжийн харилцан уялдааг хангах, зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс хуулийг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хуулийг шинээр батлах зэргээр эрх зүйн орчныг сайжруулах ажлыг тогтмол хийсэн байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 32 удаа;
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 3 удаа;
- Компанийн тухай хуульд 7 тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж хэлэлцэх шатанд байна.

Аудитын явцад хууль тогтоомжийн хэрэгжилт нь бодит байдалд хэрхэн хэрэгжиж байгаа талаар холбогдох байгууллага, ажилтнуудтай уулзалт зохион байгуулах, холбогдох байгууллагуудаас тайлан, мэдээ авч судлахад хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хүндрэл бэрхшээлтэй дараах асуудлууд байна.Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.4¹-д тухайн шатны ИТХ нь орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавихаар заасан ч зарим дүүрэгт хэрэгжээгүй байна. Тухайлбал: БЗД-ийн ИТХТ-ийн 2019 оны А/13 дугаар тогтоолоор дүүргийн орон нутгийн өмчит НҮГ-1, 2, 3, 4 үйлдвэрийн газруудыг татан буулгах шийдвэр гаргасан ч холбогдох байгууллагууд шийдвэрийг биелүүлээгүй, ИТХ-аас тогтоолын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүйгээс тус газруудын үйл ажиллагаа явагдаж байна.
- НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 1.2²-т Төрийн өмчит болон өмчийн оролцоотой компанид төр компанийн засаглалын дагуу төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох замаар төлөөллөө хэрэгжүүлэхээр заажээ. Гэвч тухайн байгууллагыг үүсгэн байгуулж байгаа ИТХ-ын гишүүд ТУЗ-д томилогдож байгаа нь улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байдал, хяналтын чиг үүрэгт сөргөөр нөлөөлөх, ИТХ-д ажлаа тайлагнадаг ЗД-ын хувьд гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний биелэлтийг тооцох боломжийг хязгаарлаж байна;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18.4³-д “Захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орохыг хориглоно” гэж заажээ. Гэвч 2 үйлдвэрийн газрын захирал ТУЗ, УЗ-ийн гишүүнээр томилогдсон байна;
- ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.8⁴-д төрийн захиргааны албан хаагч 2-оос илүү төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-д орж ажиллахыг хориглоно гэж заасан ч төрийн захиргааны 1 албан хаагч 3-5 газрын УЗ, ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон байна;
- Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 6.2.2⁵-д заасны дагуу Орон нутгийн өмчит компани нь НӨАТ төлөгч болдог байна. Энэ заалтаар санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг хязгаарлаж орон сууцыг иргэдэд худалдан борлуулсан гэх ангилалд хамааруулж зорилтот бүлгийн иргэдийг хямд өртөгтэй орон сууцаар хангах үндсэн зорилго алдагдаж иргэдэд хүрэх үнэлгээ нь 10% өсөх хүндрэл үүсэж байна. Тус заалт нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.14, 13.5.7⁶-д заасан албан татвараас чөлөөлөх тухай заалтуудтай зөрчилдөж байна.

Дүгнэлт: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж эрх зүйн зохицуулалт хангалтгүй, компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

¹ 77.4. орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

² 1.2. Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх орон нутгийн өмчийн төлөөллийг тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувь нийлүүлэгчдийн хуралд нийслэлийг төлөөлөх гишүүн /цаашид 'нийслэлийн өмчийн төлөөлөгч' гэх/ ажиллуулах, нийслэлийн өмч давамгайлсан хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлыг томилох, өөрчлөх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

³ 18.4. Захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно

⁴ Энэ журамд заасны дагуу төрийн өмчийн төлөөллийн хэрэгжүүлэхээр томилогдсон төрийн захиргааны албан хаагч 2-оос илүү төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд орж ажиллахыг хориглоно.

⁵ 6.2. Дараах эд хөрөнгө түрээсийн зүйл байж болохгүй: 6.2.2. төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө;

⁶ 13.5.7. банкны болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооны зээлийн хүү, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9.4-т заасан хүү, 10.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл, санхүүгийн түрээсийн хүү, ногдол ашиг, зээлийн баталгааны хураамж, даатгалын гэрээний хураамж төлөх үйлчилгээ;

1.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлал байна уу?

Аудитын түүвэрт ТӨХК 2, орон нутгийн өмчит ХХК 2 ХК 2, ОНӨААТҮГ 23, ОНӨТҮГ 1 нийт 30 газрыг хамруулан компанийн засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлалыг мөрдөж байгаа эсэхийг шалгасан.

Компанийн засаглалын зарчмууд:

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн олон улсын байгууллагаас (ЭЗХАХБ) Компанийн засаглалын зарчмуудыг 1999 онд анх баталж, 2004 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

СЗХ-ны 2007 оны 210 дугаар тогтоолоор "Монголын компанийн засаглалын кодекс"-ыг батлан гаргаж, МУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр байгуулагдах хувьцаат компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсөн боловч түүний хэрэгжилт төдийлөн хангалтгүй байсан байна.

ЗГ-ын 2011 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг СЗХ-ны 2011 оны 187 дугаар тогтоолоор байгуулж, үндэсний хөтөлбөрийг /нэгдүгээр үе шат 2011-2012 он, хоёрдугаар үе шат 2013-2016 он/ 2 үе шаттайгаар хэрэгжүүлжээ.

ЗГ-ын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлээр дээрх хөтөлбөрийг үргэлжлүүлэн, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллахыг СЗХ-нд зөвлөсөн байна.

СЗХ-ны 2014 оны 162 тоот тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү тогтоолын 3 дах заалтад "Монголын хөрөнгийн биржийн "А" самбар дээр бүртгэлтэй хувьцаат компаниуд (ХК) энэхүү кодексийг хэрэгжүүлж ажиллахыг, бусад хувьцаат компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаараа тайлбарлаж ажиллахыг, мөн 4 дэх заалтад "Нийт компаниуд энэхүү кодексийг мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсөн нь төрийн байгууллагын зүгээс компанийн засаглалын талаарх мэдлэг мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх суурь болсон ч хэрэгжилт хангалтгүй байна.

Дээрх үндэсний хөтөлбөр, компанийн засаглалын кодекс орон нутгийн өмчит компаниуд, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт зориулагдсан тодорхой заалт тусгагдаагүй байна.

Компанийн засаглалыг үнэлэх журмын хэрэгжилт:

СЗХ-ны 2016 оны 34 тоот тогтоолоор баталсан "Компанийн засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам"-ын зорилго нь Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангуулах, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг мөрдүүлэх, Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх, засаглалын түвшин сайжруулах зорилгоор компанийн засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, түвшин тогтоох, түүнийг хувьцаа эзэмшигчдэд тайлагнах, засаглалын тогтолцоог бий болгоход чиглэгдсэн.

Энэхүү журмаар Компанийн Засаглалын үндэсний Зөвлөл нь Хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниудад СЗХ, Монголын хөрөнгийн биржийн холбогдох дүрэм журмын хүрээнд засаглалын үнэлгээ хийж, түвшин тогтоож, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхээр журамласан байна.

Харин "Компанийн засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам"-ын 3.2-д "Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл

ажиллагаа явуулдаг 3.2.1⁷-д заасан компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно” гэж заажээ.

Засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно гэсэн заалттай холбогдуулан аудитын түүвэрт хамрагдсан компаниуд засаглалын түвшинд үүссэн хямрал буюу хуримтлагдсан алдагдлаас шалтгаалан тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөж хангалтгүй байхад журмын 3.3⁸-д заасан үнэлгээг хийлгээгүй байна. Үүнд:

- Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК 999.6 сая;
- Нийслэлийн орон сууцны корпорац ХК 3,057.8 сая;
- Олон улсын худалдаа логистикийн төв ХК 2,373.9 сая;
- Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ХХК 1,002.0 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдал үүссэн байхад засаглалын үнэлгээ хийлгүүлэх ажил зохион байгуулаагүй байна.

Компанийн засаглалыг үнэлэх түвшин тогтоох журмын хэрэгжилт хангалтгүй байна. Компанийн засаглалын кодексийг хөрөнгийн биржийн А самбарт бүртгэлтэй ХК компани хэрэгжүүлэхээр заасан, харин төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой компани засаглалыг хэрхэн удирдан зохион байгуулах, үнэлэх зарчим аргачлалтай холбоотой заалтууд тусгагдаагүй байна.

Дүгнэлт: Төрийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлалыг баталсан байна. Орон нутгийн түвшинд мөрдөх зохицуулалт байхгүй байна.

1.1.3. Төрийн эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн баримт бичиг хоорондын уялдааг хангаж, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.9⁹-д заасны дагуу ЗГ нь хуульд нийцүүлж төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн өмчийн төлөөллийн талаар тусгай журам тогтоож болохоор зохицуулсан. Үүний хүрээнд дараах журмуудыг баталжээ. Үүнд:

- ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан. Энэ журмаар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаа, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдэд тавих шаардлага, түүний эрх, үүрэг, хариуцлагын талаар зохицуулсан байна.
- НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”, “Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн ажиллах журам”, “Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах журам”-ыг тус тус баталсан. Энэ журмуудаар нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, хамтын удирдлагын менежментийг нэвтрүүлэх замаар өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх, өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор НЗД-аас НӨҮГ-ын захиралтай хөдөлмөрийн хуульд заасны дагуу Контракт

⁷ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани

⁸ Компани дараах тохиолдолд засаглалын үнэлгээ хийлгэнэ.... Компанид засаглалын түвшинд үүссэн хямралаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр үнэлгээ хийлгэнэ.

⁹ 21.9. Энэ хууль болон бусад хуульд нийцүүлж Засгийн газар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн өмчийн төлөөллийн талаар тусгай журам тогтоож болно.

байгуулах, биелэлтийг дүгнэх, урамшуулал олгох, хариуцлага тооцох зэрэг харилцааг зохицуулж байна.

- СХД-ийн ИТХ-ын 2014 оны А/145, ХУД-ийн 2017 оны А/06 дугаар тогтоолоор НИТХ-ын дээрх журамтай нийцүүлсэн журмыг баталж, орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаанд нь мөрдүүлэн ажиллаж байна.
- БГД, БЗД, СБД, ЧД, НД-үүд нь баталсан журамгүйгээс орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагааг сайжруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, зорилтот түвшнийг тодорхойлоогүй, үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитын хүрээнд түүвэрт хамрагдсан байгууллагуудын албан тушаалтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, холбогдох судалгаа, мэдээлэл авахад дараах хүндрэл бэрхшээлтэй асуудлууд байна. Тухайлбал:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29.1¹⁰-т заасны дагуу ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгүүдийг дуудлага худалдаагаар худалдах үйл ажиллагааг зохион байгуулах зардал нь тухайн эд хөрөнгийн үнэ өртгөөс хэтэрч улмаар агуулах байранд удаан хугацаагаар хадгалагдах үнэ цэнэ нь улам үнэгүйдэх тохиолдол гарч байна;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19.1.2¹¹-д заасны дагуу нийслэлд харьяа байгууллагын гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулан ажиллаж байгаа ч зарим дүүргүүдийн хувьд тус заалт хэрэгжихгүй буюу зорилтот түвшин тусгасан гэрээ байгуулдаггүйгээс санхүүгийн ашигт байдалд сөргөөр нөлөөлж байна;
- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.2.7¹²-д нягтлан бодогч, аудит хийх эрх бүхий иргэн ажиллахаар заасан байгаа нь зах зээл дээр боловсон хүчин олдохгүй байх, давхар ажил эрхэлдэг зэрэг хүний нөөцийн хомсдол үүсгэж байна;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ийн 2.2.2¹³-т заасны дагуу орон нутгийн компанийн хувьд өөрийн эзэмшил баланст байгаа орон сууцыг өмчлүүлэхдээ 5 жилээс дээш хугацаа олгож чадахгүй байдал нь нийгмийн хамгийн хүнд хэцүү нөхцөлтэй иргэдийн хувьд хугацаа бага байх тусам сард төлөгдөх төлбөрийн хэмжээ ихсэж төлбөрийн дарамтад орж, өр хуримтлагдах хүндрэл үүсгэж байна;
- НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.2¹⁴-т заасны дагуу нийслэлийн өмчийн төлөөлөгчөөр томилогдсон гишүүд ажлын тайлангаа ирүүлээгүй байна. Тухайлбал: Нийслэлийн өмчийн харилцааны газраас 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 2/1670-2/1682, 2/1686-

¹⁰ 29.1. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.

¹¹ 19.1.2. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана: “эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин”;

¹² 2.2.7. Менежментийн компани нь ТУЗ-өөс томилогдсон 3-аас доошгүй гишүүнтэй дотоод хяналтын албатай байх бөгөөд гишүүдийн 1-ээс доошгүй нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан

¹³ 2.2.2. түрээслэгч нь түрээсийн төлбөрөөс гадна түрээсэлж байгаа улс, орон нутгийн төсөв, орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 5 хүртэлх жилийн хугацаанд, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 15 хүртэлх жилийн хугацаанд тус тус сар бүр хуваарийн дагуу хэсэгчлэн төлж, түрээсийн орон сууцаа худалдан авч өмчлөх.

¹⁴ 3.2. Нийслэлийн өмчийн төлөөлөгч нь ажлын тайлангаа хагас, бүтэн жилээр Өмчийн ашиглалт, удирдлагын газарт ирүүлэх бөгөөд тус газар нь нийслэлийн өмчийн төлөөлөгчийн ажлын, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана;

2/1698, 2/1705, 2/1707 тоот албан бичгүүдээр нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн УЗ болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд нийслэлийн өмчийн төлөөлөгчөөр томилогдсон нийт 28 гишүүнд хагас, бүтэн жилийн ажлын тайланг ирүүлэхийг мэдэгдсэн ч Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК-ийн 3 гишүүн тайлан мэдээ ирүүлсэн, бусад гишүүд ажлын тайланг ирүүлээгүй байна.

Дүгнэлт: Нийслэл, орон нутгийн хэмжээнд эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоо сул, эрх зүйн орчин дутмаг байгаагаас төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зохистой түвшинд хэрэгжихгүй байна.

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжиж байна уу?

СЗХ-оос төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг баталсан.

Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дараах зорилтыг тусгаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн өмч хувьчлалын бодлогыг сайжруулах,
- 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах,

ЗГ-ын хөтөлбөрт тусгагдсан компанийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх зорилттой уялдсан арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого тогтвортой байна уу?

Компанийн засаглалын кодекс зааснаар компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн ойлголт бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо байна. Компанийн засаглалын кодекс 3 удаа шинэчлэн батлагдсан байна. Үүнд:

1. СЗХ-ны 2007 оны дугаар тогтоолоор баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-ийг хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй буюу хувьцаат компанид зориулж боловсруулсан. Хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээд өөрийн онцлогт тохируулан хэрэглэхийг зөвлөсөн боловч хэрэгжилт төдийлөн хангалтгүй байсан байна.
2. СЗХ-ны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Монголын компанийн засаглалын кодекс"-ийг мөн хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй буюу хувьцаат компанид зориулж батлагдсан. Хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээд өөрийн онцлогт тохируулан хэрэглэхийг зөвлөсөн боловч засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болгож чадаагүй. Аудитын түүвэрт хамрагдсан компаниуд үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй байна.
3. СЗХ-ны 2022 оны 145 тогтоолоор шинэчлэн баталсан компанийн засаглалын кодексийг нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк санхүү, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани мөрдөх заасан.

МУ-ын 3Г-ын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 187 дугаар тогтоолоор байгуулж, 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн.

МУ-ын 3Г-ын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа дууссантай холбогдуулан үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зөвлөлийн үйл ажиллагааг 5 зорилтын хүрээнд чиглүүлэн ажиллахыг СЗХ-д зөвлөсөн байна.

3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд засаглалын бодлогыг хэрэгжүүлэх стратеги зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- МУ-ын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж, бэхжүүлнэ;
- 3Г-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.2.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана”;
- 3Г-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.4.10 “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.

Дүгнэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдийг баталсан байна.

1.2.2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилт хангагдсан уу?

Нийслэл, дүүргийн ЗДТГ болон аудитын түүвэрт хамрагдсан орон нутгийн өмчит газрууд нь 3Г-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан *“төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах”* зорилтыг хэрэгжүүлсэн эсэхийг шалгасан.

3Г-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан *“өмч хувьчлалын бодлогыг сайжруулах”* зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах 3 зорилт арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- 1.6.1-д “Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг өгөөжийг нэмэгдүүлнэ”.
- 1.6.6-д “Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулан хэрэгжүүлнэ” зэргээр тусгасан байна.

НЗД-ын мөрийн хөтөлбөрт дээрх 2 зорилтын хүрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ. Хавсралт 1

Харин Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөрт тусгагдсан *“орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах”* зорилттой уялдсан арга хэмжээ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Дүүргүүдийн хувьд 3Д нарын мөрийн хөтөлбөрт “*өмч хувьчлалын бодлогыг сайжруулах*” зорилт дараах байдлаар тусгагдсан байна. Тухайлбал:

- БГД-ийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд олон нийтийн оролцоо хяналтыг нэмэгдүүлнэ”.
- ХУД-ын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.1 Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.
- СХД-ийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.35.1 Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулж, бүртгэлгүй болон хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг цаг тухайд нь бүрэн бүртгэлжүүлэх
- БХД-ийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2 Орон нутгийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх зэргээр тусгасан байна.

Дүүргүүдийн 3Д нар мөрийн хөтөлбөрт тусгагдсан дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллажээ. Хавсралт 2

Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан “*орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах*” зорилттой уялдсан арга хэмжээ дүүргийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Дүгнэлт: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “*өмч хувьчлалын бодлогыг сайжруулах*” зорилттой уялдсан арга хэмжээг нийслэл, дүүргийн 3Д-ын мөрийн хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлсэн байна. Харин “төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах” зорилттой холбоотой арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.2.3. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хэрэгжилт хангалттай байна уу?

Нийслэл, дүүргийн ЗДТГ болон аудитын түүвэрт хамрагдсан орон нутгийн өмчит газрууд нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “*орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх*” зорилтыг хэрэгжүүлсэн эсэхийг шалгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “*орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах*” зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах 3 зорилт арга хэмжээг тусгасан байна. Үүнд:

- Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн сан бий болгоно.
- Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани төрийн өмчит компанийн тоог бууруулна.
- Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн аж ахуй нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зэргээр тусгасан байна.

Нийслэлийн 3Д-ын мөрийн хөтөлбөрт дээрх 3 зорилтын хүрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ. Хавсралт 3

Засгийн газрын 2020-2024 оны хөтөлбөрт тусгагдсан “*компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх*” зорилттой уялдсан арга хэмжээ Нийслэлийн Засаг

дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Дүүргүүдийн хувьд 3Д нарын мөрийн хөтөлбөрт “орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах” зорилт дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

- Баянгол дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3 Дүүргийн өмч, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган, удирдлагын менежментийг сайжруулж, өмч ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2 Дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
3.1.6 Орон нутгийн өмчийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.
- Чингэлтэй дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4. Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.
3.1.4.1 Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулан, өмч хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг дээшлүүлж ажиллана.
3.1.4.2. Дүүргийн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгч эрсдэлийн удирдлагаар ханган, зөвлөмж өгч ажиллана.
Налайх дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.1 Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлнэ. 3.1.1.1 Өмчийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулж нийтийн эзэмшлийн зам талбай, түүхэн дурсгалт хөшөө, соёлын өвийг сэргээн засах орчны тохижилтыг хийх бодлогыг хэрэгжүүлнэ.
3.1.1.2 Дүүргийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн систем бий болгоно
- Багахангай дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1 Нийслэл дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ. 3.1.2 Нийслэл дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, татвар ногдуулах хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн хялбаршуулна.
- Хан-уул дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3 Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ зэргээр тусгасан байна.

Дүүргүүдийн 3Д нар мөрийн хөтөлбөрт тусгагдсан дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллажээ. Хавсралт 4

Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан “компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх” зорилттой уялдсан арга хэмжээ дүүргийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй байна.

Дүгнэлт: Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, зорилттой уялдсан арга хэмжээг нийслэл, дүүргийн 3Д-ын мөрийн хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлсэн байна. Харин “компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх” зорилттой холбоотой арга хэмжээ тусгагдаагүй байна.

1.2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувь эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага болон ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөөтэй байна уу?

2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой **98** хуулийн этгээд байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77, 78 дугаар зүйлд Нийслэл, дүүргийн ИТХ, ЗД-ын эрхийг дараах байдлаар заасан байна.

ИТХ-ийн эрхээс дурдвал:

- 77.1 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.
- 77.2.2 иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;
- 77.4-д Хурлын Тэргүүлэгчид нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.

ЗД-ийн эрхээс дурдвал:

- 78.1 Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 78.2.2 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;

Мөн хуулийн 19.1-д зааны дагуу ЗД нь ААТҮГ-ын захирлыг томилохдоо гэрээ байгуулах бөгөөд гэрээнд эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшнийг тусгахаар байна.

Нийслэлийн өмчит газруудын хувьд:

Аудитын түүвэрт хамрагдсан **28** газраас **12** газар нь ТУЗ-тай, **8** газар нь УЗ-тай, **10** газар нь ТУЗ, УЗ-гүй байна. Хавсралт 5

НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Журам, гэрээний үлгэрчилсэн загвар шинэчлэн батлах тухай” тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлд ажиллах гишүүнийг Нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн НИТХТ-ийн шийдвэрээр томилж, өөрчилдөг байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 15 үйлдвэрийн газрын УЗ-ын тайлан мэдээ, шийдвэр, холбогдох баримт, материалтай танилцахад дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- УЗ нь дээрх журмын 3.2 болон 3.8-д заасны дагуу хуралдаанаар хуулийн этгээдийн асуудлыг улиралд 1-ээс доошгүй удаа хэлэлцэн шийдвэрлээгүй;
- 5.8-д заасны дагуу хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, хэрэгжилт, биелэлтэд тавих хяналтын талаарх тайланг улирал тутам Өмчийн харилцааны газарт ирүүлээгүй байна. Тухайлбал; Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын УЗ-ийн 2021 оны хуралдааны тоог авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:
 - Ус сувгийн удирдах газар-2
 - Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар-3
 - Зорчигч тээврийн нэгтгэл-4
 - Зорчигч тээвэр гурав-

- Улаанбаатар зам засвар арчлалтын газар-1
 - Хот тохижилтын газар-3
 - Хот төлөвлөлт судалгааны институт-2
 - Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газар-1
 - Гэрлэх Ёслолын ордон-3
 - Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар-1
 - Геодези усны барилга байгууламж-1
 - Үндэсний цэцэрлэгт хүрээлэн-1 удаа тус тус хуралдсан байна.
- Үйлдвэрийн газруудын УЗ нь улирал тутам хуралдаж чаддаггүйгээс шалтгаалан шийдвэрийн хэрэгжилтийг заасан хугацаанд НӨХГ-т хүргүүлдэггүй, НӨХГ нь шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж НИТХТ-дэд шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар тогтоосон хугацаанд нь тайлагнаж чадахгүй байдалтай байна.
 - Мөн дээрх байгууллагуудын УЗ-д ихэвчлэн ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч нар байдаг бөгөөд мэргэжлийн байгууллагуудын УЗ-д томилогдон ажилласнаар тухайн байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангах, чиглэл өгөх, тулгамдсан асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэх зэрэг ажлыг шуурхай гүйцэтгэхэд хүндрэлтэй байдаг байна.
 - НӨХГ нь журмын 2.2-т “Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд нийслэлийг төлөөлөн ажиллах гишүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Өмчийн харилцааны газар хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Нийслэлийн харьяа орон нутгийн өмчийн оролцоотой 5 ХХК, ХК-аас үйл ажиллагааны тайлан мэдээ, аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг авч, хяналт тавин ажиллаж байна.
 - Нийслэлийн өмчит 4 ХК, ХХК-ний үйл ажиллагааны тайлан мэдээ, аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзэхэд ихээхэн хэмжээний өртэй, ашиггүй байгаа нь хуулийн этгээдийн хувь эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага /НИТХ/-аас авч хэрэгжүүлж буй бодлого, ТУЗ-аас гаргасан шийдвэр үр нөлөөгүй байгааг харуулж байна.
 - Журмын 3.14-т “Өмчийн харилцааны газар нь Удирдах зөвлөлийн ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг бүтэн жилээр дүгнэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.” гэж заасны дагуу Нийслэлийн харьяа орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот төсөвт 15 үйлдвэрийн газарт НӨХГ-аас бодлого, чиглэлээр хангаж, хяналт тавин ажилласан байна.
 - Харин нийслэлийн БГД, БЗД, СБД, ЧД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн Удирдах зөвлөлд ажиллах гишүүнийг ИТХ-аас томилон, ажиллуулаагүй, ЗД нар үйлдвэрийн газрын захирлуудтай байгуулсан гэрээнд эдийн засгийн үр ашгийн нэмэгдүүлэх зорилтыг нарийвчлан болон бүрэн тусгаагүй байгаа нь ЗГ-аас баримталж буй үйлдвэрийн газруудын зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлаагүй байгааг харуулж байна.
 - Мөн дүүргүүдийн үйлдвэрийн газруудад ИТХ-аас томилсон ТУЗ, УЗ байхгүйгээс тухайн үйлдвэрийн газрууд захирлын тушаалаар захирлын зөвлөлийн байгуулж ажилласан бөгөөд захирлын зөвлөл нь тухайн байгууллагын албан хаагчдаас бүрдсэн бөгөөд зөвлөл нь захиралд зөвхөн зөвлөх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Дүгнэлт. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувь эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага болон ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөө багатай, хэрэгжилт хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГТАЙ БАЙНА УУ?

2021 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 98 хуулийн этгээд байна.

Эдгээрээс аудитын түүвэрт орон нутгийн өмчит нийт 28 газар */төрийн өмчит 2 газар ороогүй дүн/* нь 1,407,8 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 290.1 тэрбум төгрөгийн орлого, 323.0 тэрбум төгрөгийн зардал, 6.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Өр авлагын тухайд 86.7 тэрбум төгрөгийн өр төлбөр, 235.2 тэрбум төгрөгийн авлагатай байна.

Дээрхээс нийт 323.0 тэрбум төгрөгийн зардлын 109.3 тэрбум төгрөг буюу 33.8%-ийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 89.6 тэрбум төгрөг буюу 27.7%-ийг Ус сувгийн удирдах газар, 39.4 тэрбум төгрөг буюу 12.2%-ийг Зорчигч тээврийн нэгтгэл, 24.7 тэрбум төгрөг буюу 7.6%-ийг Зорчигч тээвэр гурав, 18.7%-ийг бусад аж ахуйн нэгж эзэлж байна.

Хүлээж буй нийт 49.7 тэрбум төгрөгийн алдагдлын 23.3 тэрбум төгрөг буюу 46.9%-ийг Ус сувгийн удирдах газар, 12.7 тэрбум төгрөг буюу 25.5%-ийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 5.1 тэрбум төгрөг буюу 10.3%-ийг Зорчигч тээврийн нэгтгэл зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

Алдагдалд нөлөөлж буй томоохон хүчин зүйлийн нэг нь эргэлтийн бус хөрөнгө ихтэй газруудын хувьд элэгдлийн зардал мөн нийгэмд чиглэсэн үйлчилгээ эрхэлдэг газруудын холбогдох хороодын үнэ тарифын зохицуулалттай холбоотой байна.

Дээрх 98 хуулийн этгээд аудитын түүвэрт орон нутгийн өмчит 2 ХХК, 2 ХК, 23 ОНӨААТҮГ, 1 ОНӨТҮГ-ыг хамруулж, ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу 2 ТӨХК-ийг нэмж, нийт 30 байгууллагыг хамруулсан.

Түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ээс ХУД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг дүүргийн ИТХ-аас баталсан холбогдох журмын дагуу батлуулсан байна.

Харин БГД, БЗД, СБД, ЧД, НД дүүргүүдийн ЗД нар зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн захирлыг томилохдоо үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг гэрээнд тусгаагүй байна.

Дээрх 98 хуулийн этгээдэд нийт 9914 ажилтан, албан хаагчид ажиллаж байгаагаас хот төлөвлөлт, барилга, байгууламж, менежментийн салбарт 27.7% буюу 2748, хот тохижилт, хог тээвэрлэлтэд 23.6% буюу 2341, дулаан түгээлтийн аж ахуйн нэгжид 17.2% буюу 1709, нийтийн тээврийн үйлчилгээнд 16.1% буюу 1606 байгаа нь нийт ажилтан, албан хаагчдын 84.7% буюу 8404 байна.

2.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, баталсан уу?

Нийслэлийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг өмнөх оны гүйцэтгэл, зардалтай холбоотой гарсан шийдвэр, статистик мэдээллийг үндэслэн боловсруулж, НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолын дагуу Нийслэлийн өмчийн харилцааны газраар хянуулж, үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контракт гэрээний хавсралтаар батлуулж байна.

Хүснэгт 2. 2019-2021 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

№	ОНӨААТҮГ-ын нэрс	Нийт орлого						/сая.төг/
		2019 оны зорилт	2019 оны гүйцэтгэл	2020 оны зорилт	2020 оны гүйцэтгэл	2021 оны зорилт	2021 оны гүйцэтгэл	
1	ОСНААУГ	89,747.39	91,378.6	96,528.3	94,597.1	96,589.0	98,962.60	
2	УСУГ	65,180.11	66,138.4	68,159.6	66,112.8	66,262.8	69,765.75	
3	Зорчигч тээврийн нэгтгэл	38,819.16	37,361.3	37,193.0	31,011.6	34,311.1	33,764.99	
4	УБЗЗАГ	12,245.50	18,359.7	20,477.4	10,459.2	16,427.8	13,968.20	
5	Хот тохижилтын газар	13,584.16	12,841.8	15,576.7	19,571.4	14,434.4	16,815.25	
6	Зорчигч тээвэр гурав	11,611.32	11,813.7	12,689.6	23,187.3	20,877.4	16,869.95	
7	Өсвөр үе хүнс	6,255.83	6,557.8	7,654.4	2,213.5	2,677.3	1,772.91	
8	Хүнс хангамж төв	4,941.97	5,273.8	7,446.1	2,133.5	3,640.0	1,690.64	
9	Багачууд хүнс	4,049.05	4,084.8	5,172.1	1,616.5	2,768.5	1,160.44	
10	Асгат	3,424.97	2,873.9	4,835.8	992.8	1,538.6	745.90	
11	ГУББГ	3,610.40	3,785.9	5,805.4	5,418.8	5,463.8	4,370.13	
12	Хөрөнгө оруулалтын газар	2,800.67	3,017.4	5,128.5	3,767.2	3,684.9	3,794.78	
13	ХИХУГ	4,040.31	2,951.9	4,021.0	3,983.4	3,563.4	4,666.70	
14	ХТСИ	1,585.00	1,058.3	2,504.9	2,235.4	2,503.8	3,018.70	
15	Гэрлэх ёслолын ордон	1,143.05	1,139.0	1,248.6	551.1	998.0	160.60	
Нийт дүн		263,038.89	268,636.35	294,441.39	267,851.60	275,740.64	271,527.54	

Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газар нь 2020 оны зорилтот түвшингээр 294,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 346,9 тэрбум төгрөгийн зардал гарган 52,5 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 1,18 төгрөг байхаар баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газрын 2021 оны нийт орлогыг 275,7 тэрбум, нийт зардлыг 325,4 тэрбум төгрөг, алдагдлыг 49,7 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 19,9 тэрбум төгрөг байхаар тус тус баталсан.

Харин зарим дүүргүүдийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд зорилтот түвшнийг төлөвлөх, хянуулах, батлуулах талаар баримтлах журмын зохицуулалтыг ИТХ-аас батлаагүйгээс ТБОНӨТ хуулийн дагуу 3Д нар үйлдвэрийн газруудын захирлуудтай байгуулсан гэрээнд үр ашгийг хэрхэн дээшлүүлэх талаар зорилтыг тусгаагүй байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь хууль, журамд заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч зарим тохиолдолд Нийслэлээс батлагдсан журам, аргачлалыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлдэггүй, зорилтот түвшнийг батлаагүй байгаа нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

2.1.1. Төрийн өмчит хуулийн этгээд эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

Нийслэл, СХД, ХУД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг төлөвлөхдөө НИТХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “НӨҮГ-ын захиралтай байгуулах контрактын үлгэрчилсэн загвар”-ын 1 дүгээр хавсралтын “Тухайн жилийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, зорилтот түвшин” загвар маягтын дагуу өмнөх оны гүйцэтгэл, цалин норм, норматив үйлчилгээний үнэ, тарифыг баталсан шийдвэр, салбарын статистик мэдээллийг

үндэслэн боловсруулсан ч санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээг түүвэрт хамрагдсан 28 орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 3 нь хийсэн байна.

Харин зарим дүүргийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь үйлдвэрийн газруудад хууль тогтоомж мөрдөөгүй, мөн баримтлах эрх зүйн баримт бичиг болох журмууд тухайн дүүрэгт батлагдаагүй зэргээс шалтгаалан эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг боловсруулаагүй байна. Тухайлбал: Дүүргүүдийн 3Д нар зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн захирлыг томилохдоо үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг гэрээнд тусгаагүй ТБОНӨТ хуулийн 19.1¹⁵-ийг мөрдөөгүй байна.

Нийслэлийн хувьд: 2020 онд нийслэлийн өмчит ААТҮГ-ууд доорх хүчин зүйлсээс шалтгаалан эдийн засгийн зорилтот түвшнийг 47,8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөжээ. Үүнд:

- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө ашиглалтад орж бий болсонтой холбоотой элэгдлийн зардлын хэмжээ 6,5 тэрбум төгрөгөөр өссөн;
- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2018 оны 05 дугаар тогтоолоор 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс цалингийн доод хэмжээг 420000 төгрөгөөр шинэчлэн тогтоосонтой холбоотой үндсэн болон нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд өссөн.

Үнэ тарифын зохицуулалттай холбоотойгоор нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь орлогоороо зардлаа нөхөж чадахгүй, өндөр хэмжээний алдагдал хүлээсээр байгаа ба нийт алдагдлын дийлэнх хувийг дараах байгууллагууд эзэлж байна. Үүнд:

- Ус сувгийн удирдах газар 28.6 тэрбум,
- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 13.5 тэрбум,
- Зорчигч тээвэр гурав 3.4 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж байна.

Мөн нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн элэгдлийн зардлын улмаас Геодези, усны барилга байгууламжийн газар нь 3.8 тэрбумын алдагдлыг хүлээж байна.

Хүснэгт 3. 2020 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт

№	Үзүүлэлт	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	2020 оны Зорилтот түвшний төлөвлөгөө	/сая.төг/ Өсөлт, бууралт /өмнөх оны гүйцэтгэлээс/
1	Нийт орлого	224,584.5	231,451.3	257,383.7	25,932.4
2	Нийт зардал	266,502.2	266,457.0	305,260.5	38,803.5
3	Ашиг алдагдал	(41,917.6)	(35,005.7)	(47,876.8)	(12,871.1)
4	БНТН Зардал /төг/	1.2	1.2	1.1	(0.0)

2021 онд нийслэлийн өмчит ААТҮГ-ын эдийн засгийн зорилтот түвшний зардлыг 325.5 тэрбум төгрөг, алдагдлын хэмжээг 49,7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь алдагдалд нөлөөлж буй томоохон хүчин зүйлийн нэг нь эргэлтийн бус хөрөнгө ихтэй газруудын хувьд элэгдлийн зардал мөн нийгэмд чиглэсэн үйлчилгээ эрхэлдэг газруудын холбогдох хороодын үнэ тарифын зохицуулалттай холбоотой байна.

¹⁵ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана: ... 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;

Хүснэгт 4. 2021 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт

№	Үзүүлэлт	2020 оны төлөвлөгөө	2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	2021 оны Зорилтот түвшний төлөвлөлт	/сая.төг/ Өсөлт, бууралт /өмнөх оны гүйцэтгэлээс/
1	Нийт орлого	294,441.4	267,891.2	275,740.6	7,849.5
2	Нийт зардал	346,983.1	320,018.6	325,462.8	5,444.1
3	Ашиг алдагдал	(52,541.7)	(52,127.5)	(49,722.1)	2,405.4
4	БНТН Зардал /төг/	1.2	1.2	1.2	(0.0)

Нийт 325.4 тэрбум төгрөгийн зардлын 109.3 тэрбум төгрөг буюу 33.6 хувийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 89.6 тэрбум төгрөг буюу 27.5 хувийг Ус сувгийн удирдах газар, 39.4 тэрбум төгрөг буюу 12.1 хувийг Зорчигч тээврийн нэгтгэл, 24.7 тэрбум төгрөг буюу 7.6 хувийг Зорчигч тээвэр гурав, 26.8 хувийг бусад аж ахуйн нэгж эзэлж байна.

Хүлээж буй нийт 49.7 тэрбум төгрөгийн алдагдлын 23.3 тэрбум төгрөг буюу 46.9 хувийг Ус сувгийн удирдах газар, 12.7 тэрбум төгрөг буюу 25.5 хувийг Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, 5.1 тэрбум төгрөг буюу 10.3 хувийг Зорчигч тээврийн нэгтгэл зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд эзэлж байна.

Аудитын түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ээс СБД, ХУД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг дүүргийн ИТХ-аас баталсан холбогдох журмын дагуу боловсруулсан ч орлого, зардлын үзүүлэлт тус бүрээр нарийвчлан боловсруулахгүй байна.

Дүгнэлт: Орон нутгийн өмчит зарим хуулийн этгээдүүд нь эдийн засгийн зорилтот түвшнийг төлөвлөхдөө санхүүгийн үйл ажиллагааны тооцооллыг хийгүй байна.

2.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаас үндэслэлтэй хянасан уу?

НӨХГ-аас 2019-2021 оны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг хянаж, санал дүгнэлт боловсруулан төслийг НЗД-д хүргүүлжээ. Тухайлбал 2021 оны зорилтот түвшнийг хэрхэн хянасныг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Эдийн засгийн зорилтот түвшний хянасан байдал

№	Үзүүлэлт	2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	Үйлдвэрийн газраас ирүүлсэн санал	НӨХГ-ын хянасан дүн	/сая.төг/ Байгууллагаас ирүүлсэн саналаас
1	Нийт орлого	267,891.2	287,613.0	275,740.6	(11,872.4)
2	Нийт зардал	320,018.6	355,606.0	325,462.8	(30,143.3)
3	Ашиг алдагдал	(52,127.5)	(67,993.0)	(49,722.1)	18,270.9
4	БНТН Зардал /төг/	1.2	1.2	1.2	(0.1)

Аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газраас 2021 онд нийт 287.6 тэрбум төгрөгийн орлого олж, 355.6 тэрбум төгрөгийн зардал гарган нийт 67.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөө ирүүлснийг хянан зардлыг 30.1 тэрбум төгрөгөөр, алдагдлын хэмжээг 18.2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 1.2 төгрөг байхаар төлөвлөсөн байна.

Хавсралт 6

Аудитын түүвэрт хамрагдсан 6 дүүрэг болон НД-ээс СБД, ХУД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг дүүргийн

ИТХ-аас баталсан холбогдох журмын дагуу боловсруулсан ч орлого, зардлыг үзүүлэлт тус бүрээр нарийвчлан тусгахгүй байна. Энэ нь хог тээвэр, тохижилт үйлчилгээний үйлдвэрийн газруудын орлогын эх үүсвэр нь нийслэл, дүүргийн хогны төлбөрийн хураамжаас бүрдэж, бүрдсэн орлогоос хамааруулан нийслэл, дүүргээс хянаж баталдагтай холбоотой байна.

Дүгнэлт: Түүвэрт хамрагдсан газруудаас 21 газрын эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаас үндэслэлтэй хянасан байна. Харин дүүргүүдэд 9 газар зорилтот түвшнийг боловсруулаагүй байна.

2.1.3. Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага хянаж, баталсан уу?

Нийслэлийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн тухайн жилийн зорилтот түвшнийг НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолын дагуу тухайн байгууллагын УЗ-өөр хэлэлцэн шийдвэрлүүлж, НӨХГ-аар хянуулан, үйлдвэрийн газрын захирлын НЗД-тай байгуулсан контрактыг хавсралтаар баталжээ.

Аудитын түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ээс зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг хууль, журмын дагуу хянаж, батлуулахгүй байна.

ХУД-ийн ИТХ орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн тухайн жилийн зорилтот түвшнийг баталсан бол БГД, БЗД, СБД, ЧД, НД дүүргүүдийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд баримтлах эрх зүйн зохицуулалт тодорхой бус, холбогдох мөрдлөг болгох журмын дутмаг байдлаас шалтгаалан зорилтот түвшнийг батлуулж ажиллаагүй байна.

Дүгнэлт: Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий этгээдүүд хянаж, баталжээ. Харин дүүргүүдийн зарим үйлдвэрийн газруудын зорилтот боловсруулаагүй байна.

2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн үү?

Аудитын түүвэрт хамрагдсан 30 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт 96%-ийн гүйцэтгэлтэй байгаа ч нийт 30 байгууллагын 17 буюу 56.6% нь зорилтот түвшнийг баталж төлөвлөхгүй байгаагаас шалтгаалж орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг харьцуулах бүрэн дүгнэх боломжгүй байна.

2.2.1. Холбогдох хуулийн этгээд төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлсэн үү?

Аудитын түүвэрт хамрагдсан 30 хуулийн этгээдээс 2019-2021 онд 13 хуулийн этгээд зорилтот түвшин баталж, 729,036.0 сая төгрөгийн орлого, 17 хуулийн этгээд зорилтот түвшин батлаагүйгээр 90,033.0 сая төгрөгийн орлого нийт 819,068.0 сая төгрөг төвлөрүүлжээ.

Хүснэгт 6. Орлого төвлөрүүлэлт

Зорилтот түвшин батлуулсан					/сая.төг/	
№	Он	Үйлдвэрийн газруудын тоо	Зорилт	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	Хувь
1	2019	13	251,522	241,519.0	-10,004	96.00%
2	2020	13	257,916	236,951.0	-20,966	91.90%
3	2021	13	246,866	250,566.0	3,701	101.50%
Дүн			756,304	729,036.0	-27,269	
Зорилтот түвшин батлуулаагүй						
1	2019	17	-	24,612.0		

2	2020	17	-	41,862.0	17,250	70.09%
3	2021	17	-	23,558.0	-18,304	-43.72%
		Дүн		90,033.0		
		Нийт дүн		819,069.0		

Зорилтот түвшин батлуулсан газрууд орлогыг 2019 онд 4.0%, 2020 онд 8.1%-иар тус тус дутуу төвлөрүүлж, 2021 онд 1,5%-иар давуулан биелүүлсэн байна.

Харин зорилтот түвшин батлуулаагүй газрууд 2020 онд өмнөх оноос 58.8%-иар илүү орлого төвлөрүүлж, 2021 онд 55.05%-иар бага орлого төвлөрүүлсэн байна.

Зорилтот түвшин батлуулсан газруудын орлогыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Орлого төвлөрүүлэлт

№	Хуулийн этгээд ангилал	Огноо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувиар
сая.төг						
1	Гэрлэх ёслол ордон	2019	1,068.0	1,139.0	71.0	106.7%
		2020	1,249.0	551.0	(697.0)	44.1%
		2021	998.0	161.0	(837.0)	16.1%
2	ГУББГ	2019	8,085.0	3,786.0	(4,299.0)	46.8%
		2020	5,805.0	5,419.0	(387.0)	93.3%
		2021	5,464.0	4,370.0	(1,094.0)	80.0%
3	ОСНААУГ	2019	96,528.0	91,379.0	(5,150.0)	94.7%
		2020	96,528.0	94,597.0	(1,931.0)	98.0%
		2021	96,589.0	98,963.0	2,374.0	102.5%
4	ОНӨААТУГ Хот тохижилт	2019	15,911.0	12,842.0	(3,069.0)	80.7%
		2020	15,577.0	19,571.0	3,995.0	125.6%
		2021	14,434.0	16,815.0	2,381.0	116.5%
5	УСУГ	2019	68,160.0	66,138.0	(2,021.0)	97.0%
		2020	68,160.0	66,113.0	(2,047.0)	97.0%
		2021	66,263.0	71,126.0	4,863.0	107.3%
6	Зорчигч нэгтгэл	2019	38,819.0	37,361.0	(1,458.0)	96.2%
		2020	37,193.0	31,012.0	(6,181.0)	83.4%
		2021	34,311.0	33,765.0	(546.0)	98.4%
7	УБЗЗАГ	2019	12,145.0	18,360.0	6,214.0	151.2%
		2020	20,477.0	10,459.0	(10,018.0)	51.1%
		2021	16,428.0	13,968.0	(2,460.0)	85.0%
8	ХХК, ХК НОСК ХК	2019	1,218.0	1,497.0	280.0	123.0%
		2020	3,171.0	1,766.0	(1,405.0)	55.7%
		2021	3,727.0	4,149.0	422.0	111.3%
9	УБХХК ХК	2019	300.0	363.0	63.0	120.8%
		2020	500.0	505.0	5.0	101.1%
		2021	760.0	118.0	(642.0)	15.6%
10	УБХОМ ХК	2019	395.0	426.0	31.0	107.9%
		2020	1,625.0	463.0	(1,162.0)	28.5%
		2021	1,256.0	474.0	(782.0)	37.7%
11	ОУЛХТ ХК	2019	2,491.0	1,826.0	(664.0)	73.3%
		2020	2,634.0	1,381.0	(1,253.0)	52.4%
		2021	1,430.0	1,110.0	(319.0)	77.7%
12	ХК Налайх дулаан	2019	5,393.0	5,210.0	(183.0)	96.6%
		2020	3,879.0	3,721.0	(159.0)	95.9%
		2021	3,845.0	4,003.0	158.0	104.1%
13	Налайх АЗЗА	2019	1,010.0	1,192.0	182.0	118.0%
		2020	1,117.0	1,392.0	274.0	124.5%
		2021	1,361.0	1,544.0	183.0	113.4%
Нийт		2019	251,522.0	241,519.0	(10,004.0)	96.0%
		2020	257,916.0	236,951.0	(20,966.0)	91.9%
		2021	246,866.0	250,566.0	3,701.0	101.5%

2021 онд зорилтот түвшин батлуулсан хуулийн этгээдээс дараах байгууллагууд орлогыг давуулан биелүүлсэн байна. Үүнд:

- УСУГ 66,262.0 сая төгрөг төлөвлөж, 71,126.0 сая төгрөг буюу 7.3%;
- Хот тохижилт 14,434.0 сая төгрөг төлөвлөж, 16,815.0 сая төгрөг буюу 16.5%;
- Налайх АЗЗА ТӨХК 1,361.4 сая төгрөг төлөвлөж, 1,544.2 сая төгрөг буюу 13.4%-иар тус тус биелүүлсэн байна.

Дээрх байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны алдагдал багасаж, санхүүжилтийн нэмэгдсэн нь орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Харин дараах газрууд төлөвлөсөн орлогыг 40%-иар дутуу төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Гэрлэх ёслолын ордон 998.0 сая төгрөг төлөвлөж, 161.0 сая төгрөгийн орлого буюу 16.1%;
- УБХХК ХК 760.0 сая төгрөг төлөвлөж, 118 сая төгрөгийн орлого буюу 15.6%;

- УБХОМ ХК 1,256.0 сая төгрөг төлөвлөж, 474.0 сая төгрөгийн буюу 37.7%-иар тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Дээрх газрууд цар тахлын улмаас хөл хорио тогтоосноос үйлчилгээ зогссонтой холбоотой төлөвлөсөн орлого биелэх боломжгүй болсон байна.

Дээрх газруудын орлогын биелэлт хангалтгүй байгаа гол шалтгаан нь 28 хуулийн этгээдэд 2018 онд 14,822.0 сая төгрөг, 2019 онд 16,902.0 сая төгрөг, 2020 онд 149,780.0 сая төгрөгийн авлагатай байсан бол 2021 онд 236,007.0 сая төгрөг болж өссөнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл түүвэрт хамрагдсан 28 хуулийн этгээдийн жилийн орлоготой тэнцэх хэмжээний авлага үүссэн байна.


Хүснэгт 8. Авлагын судалгаа

			сая.төг					
№	Хуулийн этгээд ангилал		Хамрах огноо					
			2018	2019	2020	2021		
1	Нийслэл	ОНӨААТҮГ	Гэрлэх ёслолын ордон	20.0	1.0	14.0	19.0	
2			ГУББГ	81.0	116.0	125.0	77.0	
3			ОСНААУГ	1,724.0	2,321.0	15,996.0	23,792.0	
4			Хот тохижилт	291.0	66.0	1,489.0	527.0	
5			УСУГ	6,480.0	6,714.0	9,572.0	23,813.0	
6			Зорчигч нэгтгэл	1,071.0	1,529.0	1,541.0	787.0	
7			УБЗААГ	2,323.0	2,920.0	4,220.0	4,177.0	
8			ОНӨТҮГ	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	26.0	-	28.0	58.0
9				Улаанбаатар лифт	3.0	2.0	5.0	4.0
10			ХХК, ХК	НОСК ХК	115.0	434.0	113,746.0	179,348.0
11				Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	30.0	10.0	21.0	138.0
12				Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХК	-	-	16.0	33.0
13				Олон улсын логистик худалдааны төв ХК	825.0	581.0	471.0	467.0
14	Дүүрэг	ОНӨААТҮГ	БЗД НҮГ-1	1.0	3.0	-	20.0	
15				БЗД НҮГ-2	3.0	-	2.0	30.0
16				БЗД НҮГ-3	13.0	15.0	6.0	32.0
17				БЗД НҮГ-4	7.0	-	1.0	5.0
18				БГД Баянгол Шинэ-Өргөө	2.0	2.0	3.0	33.0
19				ХУД Хан Уул Агро	3.0	40.0	29.0	2.0
20				ХУД Хан-Уул дүүргийн Тохижилт Үйлчилгээний Төв	16.0	34.0	64.0	22.0
21				СХД Тээвэрлэлт үйлчилгээний төв	182.0	217.0	165.0	252.0
22				СХД Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ	263.0	342.0	275.0	310.0
23				СБД Сүхбаатар дэвшил менежмент	-	-	-	19.0
24				СБД Сүхбаатар Дэвшил	141.0	103.0	136.0	163.0
25				НД Чандмань Налайх	707.0	794.0	1,008.0	1,064.0
26				НД Тохижилт үйлчилгээ	2.0	2.0	-	4.0
27	Төрийн өмчит	ХК	Налайх дулаан	378.0	442.0	694.0	659.0	
28			Налайх АЗЗА	116.0	213.0	153.0	151.0	
			Нийт	14,822.0	16,902.0	149,780.0	236,007.0	

2021 онд авлагын хэмжээ өмнөх онуудаас 14%-786.2%-иар өссөн байна. Дараах байгууллагуудын авлагын хэмжээ өндөр хэмжээтэй байна. Үүнд:

- НОСК 179,348.0 сая төгрөгийн авлагаас 139,385.0 сая төгрөг нь энгийн түрээс болон түрээслээд өмчлөх байрны түрээслэгч иргэдээс авах авлага, 35,909.0 сая төгрөг нь 1000 төрийн албан хаагч иргэдээс авах хүүгийн;
- УСУГ 23,813.0 сая төгрөг, ОСНААУГ 23,792.0 сая төгрөг, Чандмань Налайх 1,064.0 сая төгрөгийн авлагууд нь ЗГ-ын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбоотойгоор үүссэн;
- УБЗЗАГ 4,177.0 сая төгрөгийн авлага нь зам засварын ажлын баталгаат хугацааны 5%-ийн барьцаатай холбоотойгоор тус тус үүсэн байна.

Өндөр авлагатай газруудыг графикаар харууллаа.



Дүгнэлт: Холбогдох хуулийн этгээдүүд төлөвлөсөн орлогыг дутуу төвлөрүүлсэн, орлогын төлөвлөгөө батлуулаагүй, жилийн орлоготой тэнцэх хэмжээний авлага үүссэн байна.

2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлсэн үү?

2019-2021 онд Нийслэл, дүүргийн аж ахуйн тооцоот газрууд улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг 18 газрын хүрээнд авч үзсэн.

Эдгээр газрууд нь 2019 онд 19,004.0 сая төгрөг, 2020 онд 25,019.0 сая төгрөг, 2021 онд 26,050.0 сая төгрөгийн татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9.Татвар, төлбөр, хураамжийн ноогдол гүйцэтгэл

ТАТВАРЫН ТӨРӨЛ		Ноогдол, төлсөн, үлдэгдэл								
		2019 он			2020 он			2021 он		
		2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
ТАТВАР	ААНОАТ	976.0	739.0	237.0	420.0	460.0	(40.0)	207.0	145.0	62.0
	АТӨХА татвар	53.0	55.0	(2.0)	68.0	64.0	4.0	61.0	64.0	(3.0)
	Бусад	9.0	6.0	3.0	10.0	12.0	(2.0)	11.0	-	-
	НӨАТ	11,230.0	9,111.0	2,119.0	13,172.0	10,561.0	2,611.0	14,632.0	16,571.0	(1,939.0)
	Тээврийн хэрэгслийн татвар	2.0	2.0	-	2.0	2.0	-	2.0	-	2.0
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	339.0	328.0	11.0	451.0	468.0	(17.0)	461.0	498.0	(37.0)
ТӨЛБӨР	ХХОАТ	6,924.0	6,669.0	255.0	7,532.0	7,095.0	437.0	7,887.0	7,924.0	(37.0)
	Агаарын бохирдлын төлбөр	2.0	2.0	-	3.0	3.0	-	6.0	3.0	3.0
	Газрын төлбөр	602.0	196.0	406.0	560.0	309.0	251.0	473.0	294.0	179.0
	Зам ашигласны төлбөр	10.0	9.0	1.0	11.0	9.0	2.0	21.0	21.0	-
	Усны нөөц ашигласны төлбөр	697.0	706.0	(9.0)	590.0	613.0	(23.0)	537.0	526.0	11.0
	Хогны төлбөр	1,103.0	1,176.0	(73.0)	2,197.0	2,196.0	1.0	1.0	1.0	-
ХУРААМЖ	Улсын тэмдэгийн хураамж	1.0	1.0	-	-	-	-	1.0	1.0	-
	Усны хураамж	4.0	4.0	-	3.0	-	-	2.0	2.0	-
Татварын дүн		19,533.0	16,910.0	2,623.0	21,655.0	18,662.0	2,993.0	23,261.0	25,202.0	(1,941.0)
Төлбөрийн дүн		2,414.0	2,089.0	325.0	3,361.0	3,130.0	231.0	1,038.0	845.0	193.0
Хураамжийн дүн		5.0	5.0	-	3.0	-	3.0	3.0	3.0	-
Нийт дүн		21,952.0	19,004.0	2,948.0	25,019.0	21,792.0	3,227.0	24,302.0	26,050.0	(1,748.0)

Төвлөрүүлсэн орлогын 90.9% нь татвар, 9.1% нь төлбөр, 0.01% нь хураамжаас бүрдсэн байна.

2019 онд 2,895.0 сая төгрөг, 2020 онд 4,470.0 сая төгрөг, 2021 онд 4,357.0 сая төгрөгийн татварын үлдэгдэлтэй 9 газар байна.

Хүснэгт 10. Татвар, төлбөр, хураамжийн үлдэгдэлтэй газрууд

№	Хуулийн этгээд нэр	2019 он	2020 он	сая.төг 2021 он
1	ОСНААУГ	520.0	1,917.0	1,845.0

2	Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ	1,481.0	1,077.0	1,171.0
3	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	238.0	694.0	608.0
4	Налайх АЗЗА	286.0	282.0	351.0
5	НАЛАЙХ ДУЛААН ТӨХК	31.0	127.0	179.0
6	СХД "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв" ОНӨААТҮГ	289.0	234.0	70.0
7	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХХК	10.0	40.0	51.0
8	БЗД Нийтлэг үйлчилгээний газар гурав	22.0	82.0	44.0
9	Гэрлэх ёслолын ордон	18.0	17.0	38.0
НИЙТ		2,895.0	4,470.0	4,357.0

2021 оны татварын өрийг газруудаар нь авч үзвэл ОСНААУГ 42.3%, УБЗАА 26.9%, Зорчигч тээврийн нэгтгэл 14.0%, бусад 16.8%-ийг эзэлж байна.

Татварын өр төлбөр 2021 онд өмнөх онуудаас 2.5-117.4%-иар өссөн байна.

Цаашид эрх бүхий байгууллагаас холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтмол хяналт хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Түүвэрт хамрагдсан газрууд татвар, төлбөр, хураамжийн орлогыг 89.2%-тай бүрдүүлсэн байна.

2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж байна уу?

Түүвэрт хамрагдсан газруудаас Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 343 тоот тушаалын хавсралтаар баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал"-ын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг Гэрлэх ёслолын ордон, ГУББГ, ОСНААУГ, Хот тохижилт, УСУГ, Зорчигч нэгтгэл, УБЗЗАГ ОНӨААТҮГ нийт 7 газар хийсэн, бусад газрууд хийгээгүй байна.

Дээрх газрууд санхүүгийн тайланд дараах судалгаа, шинжилгээг хийсэн байна. Үүнд:

- Төлбөрийн чадварын шинжилгээ;
- Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ;
- Хөрөнгө ашиглалтын шинжилгээ;
- Ашигт ажиллагааны шинжилгээ.

Аудитаар дээрх 4 шинжилгээг тулган баталгаажуулалт хийхэд дараах үзүүлэлттэй байна. Үүнд;

Төлбөрийн чадварын шинжилгээ:

А. Эргэлтийн харьцаа = Эргэлтийн хөрөнгө / БХӨТ

Энэ нь ААН-ын богино хугацаанд хөрвөх чадварыг харуулж буй үзүүлэлтээс харахад бүх газрууд зохистой түвшинд байгаа боловч эргэлтийн харьцаа буурч байгаа үзүүлэлт харагдаж байна. Эргэлтийн харьцаа буурсан ОСНААУГ, Зорчигч нэгтгэл, Гэрлэх ёслолын ордон газрууд байна.

Хүснэгт 11. Эргэлтийн харьцаа

№	Нэр	2019 он	2020 он	2021 он
1	ОСНААУГ	2.2	1.8	1.5
2	ГУББГ	6.7	2.6	3.4
3	Гэрлэх ёслолын ордон	21.1	20.4	3.8
4	УСУГ	6	5.9	31.8
5	Хот тохижилт	421.7	115.5	725.7
6	УБЗЗАГ	1.5	1.4	1.6
7	Зорчигч тээвэр нэгтгэл	1.9	1.2	0.8

Б. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа = (Мөнгөн хөрөнгө + Авлага) / БХӨТ

Харьцаанаас харахад УБЗЗАГ, Зорчигч нэгтгэл газрууд зохистой түвшинд, ХТГ, УСУГ, Гэрлэх ёслолын ордон зэрэг газрууд нь зохистой түвшнээс өндөр харагдаж байгаа нь 2021 онд өглөг буурсан, авлага нэмэгдсэн байдалтай байна.

Хүснэгт 12. Түргэн хөрвөх чадвар

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	0.4	0.5	0.6
2	Хот тохижилт	4.2	262.9	61.9
3	ГУББГ	2	3.4	1.6
4	Зорчигч нэгтгэл	0.3	0.5	0.5
5	Гэрлэх ёслолын ордон	66.7	16.4	10.5
6	ОСНААУГ	1.8	1.9	1.7
7	УСУГ	4.7	4.9	4.4

Ашигт ажиллагааны шинжилгээ:

А. Борлуулалтын өгөөж = Цэвэр ашиг / Борлуулалтын орлого

Борлуулалтын нэг төгрөг бүрээс хэчнээн хэмжээний үйл ажиллагааны ашиг олсныг харуулдаг үзүүлэлтээс харахад УБЗЗАГ нь 0,01%-ын ашиг олсон, бусад газрууд алдагдалтай ажилласан байна. Үйл ажиллагааны ашгийн түвшин ГУББГ, Гэрлэх ёслол ордон, ХТГ өндөр бууралттай байна. Энэ харьцааг өмнөх жилтэй харьцуулахад буурах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 13. Борлуулалтын өгөөж

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	0.1%	0.1%	0.1%
2	Хот тохижилт	-9.7%	-1.8%	-8.5%
3	ГУББГ	-101.3%	-71.2%	-87.9%
4	Зорчигч нэгтгэл	-1.1%	-17.7%	-15.8%
5	ОСНААУГ	-12.3%	-12.5%	-8.9%
6	УСУГ	-25.5%	-41.1%	-19.4%
7	Гэрлэх ёслолын ордон	6.4%	-64.6%	-249.0%

Б.Хөрөнгийн өгөөж = Цэвэр ашиг / Нийт хөрөнгө

Нэг жилд бүтээсэн цэвэр ашиг нь Эздийн өмчийн хэдэн хувьтай тэнцүү байгаагаар ашигт ажиллагааг хэмждэг үзүүлэлтээс харахад Гэрлэх ёслолын ордон, ГУББГ, ОСНААУГ, Хот тохижилт, УСУГ, Зорчигч нэгтгэл, УБЗЗАГ газрууд нийт хөрөнгийн нэг төгрөг тутамд ногдож буй цэвэр ашгийн хэмжээ алдагдалтай байна. Эдгээр газруудын хөрөнгийн өгөөж буурсан байна.

Хүснэгт 14. Хөрөнгийн өгөөж

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	0.4	0.6	0.4
2	Хот тохижилт	-6.8	-1.8	-5.6
3	ГУББГ	-5.9	-6	-5.9
4	Зорчигч нэгтгэл	-1.2	-17.4	-18.2
5	ОСНААУГ	-7.7	-8.5	-6.4
6	УСУГ	-4.6	-7.4	-3.2
7	Гэрлэх ёслолын ордон	1.9	-9.3	-10.3

В.Цэвэр активын өгөөж /төрийн өмчийг ашигласны өгөөж/ = Цэвэр ашиг / Нийт хөрөнгө

Үзүүлэлтээс харахад цэвэр активын өгөөж Гэрлэх ёслолын ордон, ГУББГ, ОСНААУГ, Хот тохижилт, УСУГ, Зорчигч нэгтгэл, УБЗЗАГ газрууд цэвэр активын өгөөж буурч байна.

2019-2021 онд бүгд бууралттай байна .

Хүснэгт 15. Цэвэр активын өгөөж

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	0.2	0.3	0.2
2	Хот тохижилт	-5.9	-1.5	-4.8
3	ГУББГ	-5.9	-5.9	-5.8
4	Зорчигч нэгтгэл	-2.6	-51.5	-97.2
5	ОСНААУГ	1.4	-7.7	-9.5
6	УСУГ	-8	-13.8	-2.9
7	Гэрлэх ёслолын ордон	-10.5	-11.4	-8.5

Өрийн хөшүүргийн үзүүлэлт:**А. Өрийн харьцаа = Өр төлбөрийн нийт дүн / Өр төлбөр ба ЭӨ-ийн дүн**

Нийт хөрөнгийн хэдэн хувь нь өр төлбөрөөс бүрдсэнийг харуулдаг үзүүлэлтээс харахад нийт эх үүсвэрийн талын 50%-иас дээш өр төлбөртэй УБЗЗАГ, ЗНГ, УСУГ газрууд байна. Энэ төлбөр өндөр байхад урт болон богино хугацааны санхүүжилт хийхэд хүндрэлтэй болдог.

Хүснэгт 16. Өрийн харьцаа

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	49.1%	53.2%	47.2%
2	Хот тохижилт	0.0%	0.1%	0.0%
3	ГУББГ	0.1%	0.7%	0.8%
4	Зорчигч нэгтгэл	62.0%	73.9%	84.9%
5	ОСНААУГ	1.2%	0.9%	3.1%
6	УСУГ	48.5%	51.8%	0.4%
7	Гэрлэх ёслолын ордон	30.9%	35.5%	38.9%

Б. Өр төлбөр ба ЭӨ-ийн харьцаа = Өр төлбөрийн нийт дүн / ЭӨ-ийн дүн

Уг үзүүлэлт цэвэр хөрөнгө өр төлбөртэй хэрхэн харьцаж байгааг харуулдаг. Цэвэр хөрөнгө 50%-иас дээш хувь эзэлж байгаа УБЗЗАГ, ЗНГ, УСУГ, ОСНААУГ-ууд байна.

Хүснэгт 17. Өр төлбөр ба ЭӨ-ийн харьцаа

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	96.4%	113.8%	89.4%
2	Хот тохижилт	0.0%	0.1%	0.0%
3	ГУББГ	0.1%	0.7%	0.8%
4	Зорчигч нэгтгэл	163.1%	283.8%	561.0%
5	Гэрлэх ёслолын ордон	1.2%	0.9%	3.2%
6	УСУГ	44.6%	55.1%	63.5%
7	ОСНААУГ	94.1%	107.7%	0.4%

Хөрөнгийн ашиглалтын үзүүлэлт:**А. Дансны авлагын эргэц = Борлуулалтын орлого / Авлага /үдаа/**

Борлуулалтын авлагаа хугацаанд нь барагдуулах нь ААН-ын үйл ажиллагааны гол хэсэг байдаг, ААН-ын авлагын эргэц сайжирсан ГУББГ, ХТГ, авлагын эргэц муудсан ОСНААУГ, УСУГ, УБЗЗААГ газрууд байна.

Хүснэгт 18. Дансны авлагын эргэц

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ		25	15
2	Хот тохижилт	196	14	32
3	ГУББГ	33	47	57
4	ОСНААУГ	39	6	3
5	УСУГ	39	8	4
6	Гэрлэх ёслолын ордон	4,857	42	8,56
7	Зорчигч нэгтгэл	26	22	

Б. Авлага цуглуулах хугацаа = 365 / Авлагын эргэц

Авлага цуглуулах дундаж хугацааны үзүүлэлтээр ГУББГ, ХТГ буурсан үзүүлэлттэй, УСУГ, ОСНААУГ, УБЗЗААГ сайжирсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 19. Өрийн харьцаа

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ		14,8	24,5
2	Хот тохижилт	2	26	11
3	ГУББГ	11	8	6
4	Зорчигч нэгтгэл	14	16	
5	ОСНААУГ	9	62	107
6	УСУГ	9	45	83
7	Гэрлэх ёслолын ордон	0	0	0

Санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт:**А. Бие даах чадварын коэффициент = ЭӨ / Нийт өр төлбөр эздийн өмчийн дүн**

Бие даах чадварын коэффициент нь ААН-ын гадаад эх үүсвэрээс хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах чадварыг харуулдаг ба ЗНГ нь зохистой харьцаанаас доогуур үзүүлэлттэй байна.

Хүснэгт 20. Бие даах чадварын коэффициент

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	УБЗЗАГ	0.51	0.47	0.53
2	Хот тохижилт	1.00	1.00	1.00
3	ГУББГ	1.00	0.99	0.99
4	Зорчигч нэгтгэл	0.38	0.26	0.15
5	ОСНААУГ	0.69	0.64	0.61
6	УСУГ	0.52	0.48	1.00
7	Гэрлэх ёслолын ордон	0.99	0.99	0.97

Б. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал

2019-2021 онд борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал бүгд алдагдалтай байна.



Хүснэгт 21. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал

№	Хуулийн этгээд	2019 он	2020 он	2021 он
1	Зорчигч нэгтгэл	1.01	1.18	1.16
2	ОСНААУГ	1.10	1.11	1.09
3	УБЗЗАГ	1.00	1.00	1.00
4	Хот тохижилт	1.10	1.01	1.09
5	ГУББГ	2.01	1.71	1.88
6	УСУГ	1.18	1.28	1.19
7	Гэрлэх ёслолын ордон	0.91	1.60	3.42

Санхүүгийн тайлангийн балансын шинжилгээ:

Дээрх 7 газрын санхүүгийн байдлын тайлан дах хөрөнгийн дүн өмнөх оноос 74,954.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд эргэлтийн бус хөрөнгө 64,647.1 сая төгрөг, эргэлтийн хөрөнгө 8,280.0 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Өр төлбөр ба эздийн өмчийг задлан нийт дүнд эзлэх хувиар ангилан харуулбал


График 2. Нийт хөрөнгөд эзлэх санхүүгийн үзүүлэлт



Голлох өөрчлөлтүүд:

- 1.Эргэлтийн хөрөнгийн өсөлт авлагын өсөлттэй шууд хамааралтай байна.
2. Биет хөрөнгийн эзлэх хувь өнгөрсөн онтой харьцуулахад буурсан байна.
- 3.Цэвэр хөрөнгө өнгөрсөн онуудаас өндөр өсөлт хийсэн байна.
4. Урт хугацаат өр төлбөр өнгөрсөн нэмэгдсэн байна.

График 3. Орлогын тайлангийн шинжилгээ:



ААН-үүдийн 2018-2021 оны орлогын тайланг харахад 4 жил дараалан алдагдалтай ажилласан байна. Үүнд:

- 2018 онд 229,141.0 сая төгрөг орлоготой, орлогод эзлэх зардлын хувь -15.0%;
- 2019 онд 257,500.0 сая төгрөг орлоготой, орлогод эзлэх зардлын хувь -14.5%;
- 2020 онд 279,204.0 сая төгрөг орлоготой, орлогод эзлэх зардлын хувь -20.4%;
- 2021 онд 272,710.0 сая төгрөг орлоготой, орлогод эзлэх зардлын хувь -14.0% тус тус байна.

Орлогын тайлангаас урсгал зардлыг задалж харуулбал:



2021 онд хангамж бараа материалын зардал өмнөх оноос 1,9%, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0.4%, бусад зардал 0.7%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 22. Алдагдлын талаар

Үзүүлэлт	Тоон үзүүлэлт				Өсөлтийн хувь		
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
ОРЛОГЫН ДҮН	212,886	231,005	240,449	239,168	8.50%	4.10%	-0.50%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	229,141	257,500	279,204	272,710	12.40%	8.40%	-2.30%
Татвар төлөхийн өмнөх ашиг	-32,524	-33,961	-49,300	-33,588	4.40%	45.20%	-31.90%
Орлогын татварын зардал	646	454	233	35	-29.70%	-48.70%	-85.10%
Татварын дараах цэвэр ашиг	-31,879	-33,507	-49,067	-33,554	5.10%	46.40%	-31.60%

Судалгаанаас үзэхэд ААН-үүдийн 2018-2021 оны татвар төлөхийн өмнөх ашиг жил тутам өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

- 2019 онд -1,437.0 сая төгрөг татварын алдагдал, алдагдалд эзлэх хувь -14.5%;
- 2020 онд -15,339.0 сая төгрөг татварын алдагдал, алдагдалд эзлэх хувь -14.5%;
- 2021 онд 15,172.0 сая төгрөг татвар төлж, алдагдалд эзлэх хувь 14.5%-аар тус тус нэмэгдүүлсэн байна.

Дээрх санхүүгийн тайлангийн харьцааны шинжилгээнээс харахад дараах байдалтай байна. Үүнд,

- Орлогын хувьд 2018-2021 оны хооронд хуримтлагдсан үр дүн алдагдалтай явсан бууруулах талаар арга хэмжээ аваагүй байна.

- Зардлын хувьд 2018-2021 оны үйл ажиллагааны зардлын өсөлт сүүлийн 3 жилийн дунджаар 18,5%-ын өсөлттэй байна. Зардлын голлох өсөлт хангамжийн зардал, цалингийн зардал, эд хогшил, урсгал засварын зардал өссөнтэй холбоотой байна.
- Ашиг, алдагдлын хувьд 2018-2021 оны хооронд борлуулалтын өгөөж, хөрөнгийн өгөөж алдагдсан харьцаа алдагдсан байна.

Аудитаар хийсэн санхүүгийн шинжилгээгээр зөрүүтэй байдал үүсээгүй, харин зарим газрууд харьцааны шинжилгээ хийхэд тоон мэдээллийг зөрүүтэй илэрхийлсэн байдлыг цаашид анхаарах нь зүйтэй.

Дүгнэлт: Аудитад хамрагдсан 30 газраас 7 газар санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, судалгаа хийсэн байна.

2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг дүгнэж байна уу?

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээнийхээ үр дүнд орлого нэмэгдүүлэх, алдагдал, авлага, өглөг бууруулах чиглэлээр дараах үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Тухайлбал:

Орлого нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан байна.

Үүнд:

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ:

- Усны эрэлтийн менежментийг сайжруулах талаарх Зөвлөх багийн зөвлөмжийн дагуу хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөрөнгийн менежментийг сайжруулах хөтөлбөр боловсруулж дуусгах
- Орлого болоогүй усны хэрэглээг тогтмол хянаж, нууц хэрэглээг илрүүлэх
- Гэр хорооллын усны нэг хүний хоногийн хэрэглээг нэмэгдүүлэх талаар 24 цагийн үйлчилгээтэй Ухаалаг ус түгээх байруудыг нэмэгдүүлэх.

ОСНААУГ ОНӨААТҮГ:

- Инженерийн шугам сүлжээний нэгдсэн удирдлага, автоматжуулалт, алсын зайн хяналт, тохируулгыг хийх боломжтой “Scada” системийг Ус дулаан дамжуулах 5 төвд нэвтрүүлэх.

Ашиг, алдагдал бууруулах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ:

- Үйлдвэрлэлийг автоматжуулах, программ хангамжийн талаар нэгдсэн бодлого баримталж тууштай хэрэгжүүлэх;
- 2020 онд Улаанбаатар хотын ус хангамж ариутгах татуургын үйлчилгээний тогтвортой байдлыг хангаж, Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпораци хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний үндсэн нөхцөлийг хангах зорилгоор ХСУХАТАУ33-тэй хамтран 2021-2030 он хүртэлх “Зардал нөхөх төлөвлөгөө”-г боловсруулж дуусгах;
- Үр ашигтай хөрөнгө оруулалтыг хийж, өгөөжийг тухай бүрд нь тооцож ажиллах.

Дүгнэлт. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн үр ашгийн тооцоо, шинжилгээний үр дүнд орлого нэмэгдүүлэх, алдагдал, авлага, өглөг бууруулах чиглэлээр арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

2.3.3.Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий гэрээг үр ашигтай хэрэгжүүлж байна уу?

1. Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1¹⁶, 87.1.2¹⁷-д зааснаар хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй хэлцлийг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна. Түүвэрт хамрагдсан төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 4, нийт 6 компани хуульд заасан дээрх үнийн дүнтэй их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.
2. Дээрх хуулийн 85.1¹⁸, 91.3¹⁹-д компани нь өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах, сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргах талаар тусгажээ. Аудитын түүвэрт хамрагдсан төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 4 ХК нь сонирхлын зөрчил бүхий гэрээт ажил хэрэгжүүлээгүй байна.
3. Харин өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангаагүй Налайх АЗЗА ТӨХК, НОСК ХХК, УБХОМК ХХК, ОУХЛТ ХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийг зөрчсөн байна.

Дүгнэлт: Аудитын түүвэрт хамрагдсан төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 4 ХК нь хуульд заасан их хэмжээний хэлцэл хийгээгүй, сонирхлын зөрчил бүхий гэрээт ажил хэрэгжүүлээгүй байна. Сонирхлын зөрчлийн жагсаалт гаргаагүй нь Компанийн тухай хуулийг зөрчсөн байна.

2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангахгүй байгаад дараах нөхцөл байдал нөлөөж байна. Тухайлбал.

Улаанбаатар хотын ус дулаан дамжуулах, цэвэр бохир ус түгээх, татах, нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, үерийн ус зайлуулах, зам, гудамж талбайг цэвэрлэх зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээг үзүүлж буй ОНӨААТҮГ-уудын орлогыг бүрдүүлж буй үнэ, тариф нь шинэчлэгдээгүй, зах зээлийн үнээс доогуур байдгаас хамаарч гарсан зардлаа нөхөж чаддаггүй, хөрөнгө санхүүгээс шалтгаалж их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж чаддаггүй, шугам хоолой, машин, тоног төхөөрөмжийг шаардлагатай хэмжээнд шинэчилж чадаагүйгээс элэгдлийн зардал өндөр, зарим сэлбэг хэрэгсэл худалдаанд гарахаа больсон зэргээс шалтгаалж байна.

Түүвэрт хамрагдсан 30 орон нутгийн өмчит байгууллагуудад НТАГ-аас 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 722.4 сая төгрөгийн 45 төлбөрийн акт тогтоож, 15,995.3 сая төгрөгийн зөрчилд 92 албан шаардлага өгч, 38,440.3 сая

¹⁶ 87.1.1.хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

¹⁷ 87.1.2.компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

¹⁸ 85.1.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 хоногийн дотор компанид мэдэгдэнэ.

¹⁹ 91.3.Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

төгрөг алдаа дутагдлыг дахин давтан гаргахгүй байх 265 чиглэлийн зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллажээ.

2.4.1. Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

НИТХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “НӨҮГ-ын захиралтай байгуулах контрактын үлгэрчилсэн загвар”-ын 1 дүгээр хавсралтын “Тухайн жилийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, зорилтот түвшин” загвар маягтын дагуу орон нутгийн өмчит газрууд удирдлагын зардлыг зорилтот түвшинд тусган батлуулдаггүй байна. Харин төрийн өмчит 2 газар, орон нутгийн өмчийн оролцоотой 4 ХК дээр зардлыг 2019-2021 оны зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөндөө тусгажээ. Удирдлагын зардлын зарцуулалтыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Налайх дулааны станц ТӨХК: Эрчим хүчний сайдын 2019 оны 23, 239, 2020 оны 14, 179, 2021 оны А/15 дугаар тушаалуудаар баталсан Налайх дулааны станц ТӨХК-ийн 2019-2021 оны зорилтот түвшинд туссан удирдлагын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд 2019 оны удирдлагын зардлыг 142.0 сая төгрөгөөр төлөвлөж, 153.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 11.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
2. Нийслэлийн өмчит 4 ХХК, ХК-ийн 2019-2021 оны орлого, зардал, ашиг алдагдлыг харахад төсвийн санхүүжилтээр 2,464.0 сая, өөрийн орлогоор 13,412.3 сая, нийт 15,876.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, удирдлага болон цалингийн зардалд нийт 7,326.9 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт 3 жилийн байдлаар 5,612.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 23. Нийслэлийн өмчит ХХК, ХК-ийн орлого, зардал, ашиг/алдагдал

№	Хуулийн этгээдийн нэр	Төсвийн санхүүжилт	Өөрийн олсон орлого	Удирдлагын зардал	Цалингийн зардал	/сая.төг/ Ашиг/алдагдал
1	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	1,291.7	331.3	-	1,048.1	(191.8)
2	Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ХК	300.0	1,036.1	1,203.7	954.9	(1,002.1)
4	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК	350.0	7,062.4	-	2,687.2	(2,745.6)
5	Олон улсын худалдаа логистикийн төв ХК	522.3	4,982.5	-	1,433.0	(1,672.9)
	Нийт	2,464.0	13,412.3	1,203.7	6,123.2	(5,612.5)

Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг батлахдаа “Удирдлагын зардал” гэсэн үзүүлэлтээр батладаггүй харин “Удирдах зөвлөлийн зардал” гэсэн үзүүлэлтийг зорилтот түвшинд тусган 361.6 сая төгрөг төлөвлөж 303.2 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 24. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын удирдах зөвлөлийн зардлын үзүүлэлт

№	ОНӨААТҮГ-ын нэрс	2019 оны зорилт	2019 оны гүйцэтгэл	УЗ-ийн зардал зорилт, гүйцэтгэл	2020 оны зорилт	2020 оны гүйцэтгэл	2021 оны зорилт	2021 оны гүйцэтгэл
1	ОСНААУГ	-	-	-	-	-	-	-
2	УСУГ	44.5	37.9	42.4	25.6	43.7	42.7	42.7
3	Зорчигч тээврийн нэгтгэл	-	-	-	-	-	-	-
4	УБЗЗАГ	28	21.1	34.6	14.1	34.9		

5	Хот тохижилтын газар	-	-	-	23	34.6	34.6
6	Зорчигч тээвэр гурав	-	-	-	-	-	-
7	Өсвөр үе хүнс	-	-	-	-	-	-
8	Хүнс хангамж төв	-	-	-	-	-	-
9	Багачууд хүнс	-	-	-	-	-	-
10	Асгат	-	-	-	-	-	-
11	ГУББГ	26.6	26.3	34.7	18.4	30.2	23.8
12	Хөрөнгө оруулалтын газар	-	-	-	-	-	-
13	ХИХУГ	-	-	-	-	-	-
14	ХТСИ	23	23	34	12.6	29.6	-
15	Гэрлэх ёслолын ордон	-	-	-	-	-	-
Нийт дүн		122.1	108.4	145.8	93.7	173.1	101.1

Удирдах зөвлөлийн зардлын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, гишүүдийн тоог харгалзан тооцож, төлөвлөдөг байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаа явуулж буй нийслэлийн өмчит 15 ААТҮГ-аас 2019-2021 онуудад зорилтод түвшинд удирдах зөвлөлийн зардлыг тогтмол баталж ирсэн 4 байгууллага байгаа нь байгууллагуудын УЗ нь журмын 3.8-д заасны дагуу удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсвийг хэлэлцэж, зорилтот түвшинд тусгаагүй байгааг харуулж байна.

Дээрх үйлдвэрийн газруудын зорилтот түвшний орлого, зардлын үзүүлэлтийг хэрхэн батлах талаар мөрдлөг болгож буй журмуудад нарийвчлан зааж өгөөгүй байна.

Тухайлбал зарим үйлдвэрийн газрууд нь зорилтот түвшнийг ТУЗ болон УЗ-өөр батлуулан гаргаагүй байгаа боловч санхүүгийн аудитдлагдсан тайланд гаргасан байгаа нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Дүгнэлт: Удирдлагын зардлыг оновчгүй төлөвлөж, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

2.4.2. Үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу? /батлагдсан орон тоонд нийцүүлэн цалин урамшууллыг олгож байна уу?/

Аудитын түүвэрт хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг батлагдсан зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлснийг авч үзэхэд дараах байдалтай байна.

1. Налайх дулааны станц ТӨХК: Эрчим хүчний сайдын 2019 оны 23, 239, 2020 оны 14, 179, 2021 оны А/15 дугаар тушаалуудаар баталсан Налайх дулааны станц ТӨХК-ийн 2019-2021 оны зорилтод түвшинд туссан үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд: 2019 оны үйл ажиллагааны зардлыг 5,393.0 сая төгрөгөөр төлөвлөж, 5,210.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 182.8 сая төгрөгөөр хэмнэсэн ч нийт цалингийн санг төлөвлөгөөнөөс 30.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
2. Налайх АЗЗА: ТӨБЗГ-ын 2018 оны 659, 2019 оны 580, 2020 оны 630 дугаар тогтоолоор баталсан Налайх АЗЗА ТӨХК-ийн 2019-2021 оны зорилтод түвшинд туссан үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд: Үйл ажиллагааны зардлыг 2019 онд 89.6 сая, 2020 онд 52.0 сая, 2021 онд 374.0 сая, нийт 515.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь зам засварын ажилд шаардлагатай байдаг тоног төхөөрөмжийн түрээсийн зардал, түлш шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Нийслэлийн өмчит ААТҮГ нь НЗД-ын 2019 оны А/793, 2020 оны А/497, 2021 оны А/369 дугаар захирамжуудаар батлагдсан зорилтот түвшинд туссанаар 3 жил үйл ажиллагааны нийт зардалд 981.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 52.8 тэрбум төгрөгийн хэмнэсэн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 25. Нийслэлийн орон нутгийн өмчит аж ахуйн
тооцоотой үйлдвэрийн газруудын 2019-2021 оны зардлын үзүүлэлт**

№	ОНӨААТҮГ-ын нэрс	Нийт зардал									/сая. төв/
		2019 оны зорилт	2019 оны гүйцэтгэл	2019 оны зөрүү	2020 оны зорилт	2020 оны гүйцэтгэл	2020 оны зөрүү	2021 оны зорилт	2021 оны гүйцэтгэл	2021 оны зөрүү	
1	ОСНААУГ	100,814.01	102,441.54	1,627.53	109,979.68	106,460.72	-3,518.96	109,314.05	107,742.34	-1,571.71	
2	УСУГ	85,148.89	83,002.28	-2,146.60	96,746.19	93,302.14	-3,444.04	89,620.11	84,265.29	-5,354.82	
3	Зорчигч тээврийн нэгтгэл	42,821.03	37,781.16	-5,039.88	41,882.89	36,487.90	-5,394.99	39,455.33	39,093.20	-362.13	
4	УБЗЗАГ	12,145.29	18,345.08	6,199.79	20,213.76	12,811.86	-7,401.89	16,086.66	13,955.08	-2,131.58	
5	Хот тохижилтын газар	15,910.60	14,082.77	-1,827.82	15,249.56	19,916.22	4,666.66	15,202.99	18,246.05	3,043.06	
6	Зорчигч тээвэр гурав	15,293.62	13,294.24	-1,999.38	16,069.26	23,164.15	7,094.89	24,799.99	15,422.40	-9,377.59	
7	Өсвөр үе хүнс	6,180.18	6,465.23	285.06	7,505.25	2,421.83	-5,083.42	2,709.03	1,918.41	-790.62	
8	Хүнс хангамж төв	4,892.58	5,263.01	370.43	7,398.81	2,317.44	-5,081.38	3,666.49	1,924.73	-1,741.76	
9	Багачууд хүнс	4,027.22	4,039.60	12.37	5,068.46	1,789.34	-3,279.12	2,755.41	1,314.76	-1,440.66	
10	Асгат	3,390.40	2,839.00	-551.4	4,756.65	1,228.52	-3,528.14	1,568.25	946.87	-621.38	
11	ГУББГ	8,085.19	7,622.16	-463.03	9,631.32	9,279.27	-352.05	9,284.97	8,212.92	-1,072.04	
12	Хөрөнгө оруулалтын газар	2,735.11	2,919.21	184.11	4,828.67	4,128.82	-699.85	3,520.45	3276.7343	-243.72	
13	ХИХУГ	4,897.70	3,541.99	-1,355.72	4,021.02	3,577.87	-443.15	4,104.44	5,041.48	937.04	
14	ХТСИ	1,548.77	1,235.22	-313.55	2,477.54	2,171.26	-306.27	2,442.25	2,750.62	308.37	
15	Гэрлэх ёслолын ордон	1,067.80	1,066.45	-1.36	1,154.01	907.37	-246.64	932.35	560.44	-371.91	
Нийт дүн		308,958.39	303,938.94	-5,019.45	346,983.07	319,964.72	-27,018.35	325,462.76	304,671.30	-20,791.46	

2019-2021 онд ААТҮГ нь батлагдсан зорилтот түвшнээс нийт 52,829.3 сая төгрөгийн хэмнэлтийг үүсгэсэн байгаа боловч зарим үйлдвэрийн газрууд нь 2019 онд 8,679.3 сая, 2020 онд 11,761.5 сая, 2021 онд 4,288.5 сая нийт 24,729.3 сая төгрөгийн хэтрэлтийг үүсгэсэн бөгөөд шалтгаан тайлбарыг авч үзвэл дараах байдалтай байна.

- Усны үнэ тарифт өөрчлөлт орсонтой холбоотой худалдан авах усны үнэ 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
- Нийт ажиллагсдын цалинг 2020 оны 01 сарын 01-ээс ажилтны үндсэн цалинг 65.0 мянган төгрөгөөр буюу 8 хувиар нэмэгдүүлсэн нь цалингийн зардлыг 4.1 тэрбум төгрөгөөр өсгөж, түүнтэй холбоотой нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 дахь заалтын дагуу 2019.01.01-ээс ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээг 12.5 хувиар тооцон 512.5 сая төгрөгөөр нэмэгдэхээр
- Банктай байгуулсан гэрээний дагуу төлбөр хураах үйлчилгээний хөлс 1 өрхөд 120.0 төгрөг болж нэмэгдсэн мөн пос машинаар хураах орлогын дүн өссөн тул банкны үйлчилгээний зардал 23.8 сая төгрөгөөр;
- Интернэтийн орчинд ажиллах ABIS борлуулалтын программыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан интернэтийн хурдын нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тул харилцаа холбооны зардлыг 36.3 сая төгрөгөөр;
- ЭХХХ цахилгааны тарифыг 2019 оны 3 сараас нэмэгдүүлснээс зардал 590.7 сая төгрөгөөр;
- 2019 оны жилийн эцэст бүртгэлд авсан хөрөнгийн элэгдлийн зардал 380.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийслэлийн өмчит зарим газруудын үйл ажиллагааны зардлын зарцуулалтын байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Хот тохижилтын газар ОНӨААТҮГ: 2019 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 303.8 сая төгрөгөөр хэмнэсэн ч ашиглалтын зардлыг 105.9 сая, түрээсийн зардлыг 7.2 сая, хөдөлмөр хамгааллын зардлыг 54.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. 2020 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 86.7 сая, хангамжийн материалын зардлыг 653.6 сая төгрөгөөр хэтрүүлжээ.
2. ОСНААУГ ОНӨААТҮГ: 2019 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 324.2 сая төгрөгөөр хэмнэсэн боловч, сургалтын зардлыг 9.6 сая, хангамжийн зардлыг 126.8 сая, гаднын үйлчилгээний зардлыг 190.8 сая төгрөгөөр хэтрүүлсэн. 2020 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 86.7 сая, хангамжийн материалын зардлыг 653.6 сая төгрөгөөр хэтрүүлжээ.
3. Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ: 2019 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 1,852.7 сая төгрөгөөр хэмнэсэн боловч, төслийн зардлыг 23.3 сая төгрөгөөр хэтрүүлжээ. 2020 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 1,116.2 сая төгрөгөөр хэмнэсэн боловч, хангамжийн зардлыг 8.2 сая төгрөгөөр хэтрүүлжээ.
4. Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ: 2019 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 1,852.7 сая төгрөгөөр хэмнэсэн боловч, төслийн зардлыг 23.3 сая төгрөгөөр хэтрүүлжээ. 2020 онд батлагдсан зорилтоос цалингийн зардлыг 770.4 сая төгрөгөөр хэмнэсэн боловч, сэлбэг хэрэгслийн зардлыг 54.9 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

Аудитын түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ээс СХД, ХУД-ийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн зорилтот түвшнийг гаргах үлгэрчилсэн журмыг дүүргийн ИТХ-аас баталсан ч нийтлэг байдлаар мөрдөхгүй байна.

Харин дүүргүүдийн орон нутгийн өмчит зарим хуулийн этгээдүүд нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг гаргаж, орлого, зардал, ашиг алдагдлын төлөвлөлтийг хийхгүй байна.

Нийслэл, дүүргийн зардал үр ашгийн зохистой харьцаа хангаагүй, алдагдалтай ажиллаж буй зарим орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн хэрэгжүүлж буй чиг үүргийг шилжүүлэх боломжтой бусад төрийн байгууллагуудад шилжүүлэн нэгтгэх, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой ажил, үйлчилгээг хийлгэх, зарим зайлшгүй шаардлагатай төрийн ажил, үйлчилгээ явуулж буй үйлдвэрийн газруудын хэлбэрийг өөрчлөх шаардлагатай байна.

Хүснэгт 26. Нийслэлийн өмчит ААТҮГ-ын 2019-2021 оны ашиг, алдагдал

№	ОНӨААТҮГ-ын нэрс	Ашиг, алдагдал			/тэрбум.төг/ БНТНЗ
		2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	
1	ОСНААУГ	(11.06)	(11.86)	(8.78)	1.13
2	УСУГ	(16.86)	(27.19)	(14.50)	1.35
3	Зорчигч тээврийн нэгтгэл	(0.42)	(5.48)	(5.33)	1.15
4	УБЗЗАГ	0.01	(2.35)	0.01	0.98
5	Хот тохижилтын газар	(1.24)	(0.34)	(1.43)	1.05
6	Зорчигч тээвэр гурав	(1.48)	0.02	1.45	1.19
7	Өсвөр үе хүнс	0.09	(0.21)	(0.15)	1.01
8	Хүнс хангамж төв	0.01	(0.18)	(0.23)	0.99
9	Багачууд хүнс	0.05	(0.17)	(0.15)	0.99
10	Асгат	0.03	(0.24)	(0.20)	1.02
11	ГУББГ	(3.84)	(3.86)	(3.84)	1.70
12	Хөрөнгө оруулалтын газар	0.10	(0.36)	0.52	0.96
13	ХИХУГ	(0.59)	0.41	(0.37)	1.15
14	ХТСИ	(0.18)	0.06	0.27	0.98
15	Гэрлэх ёслолын ордон	0.07	(0.36)	(0.40)	0.93
	Нийт дүн	(35.30)	(52.11)	(33.14)	1.18

Нийслэлийн өмчит 15 ААТҮГ нь 2019-2021 онд нийт 120.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байгаагаас Улаанбаатар хотын иргэдийн эрх, ашиг,

аюулгүй байдлыг хангахад шаардлагатай төрийн ажил, үйлчилгээ явуулж буй УСУГ 58.5 тэрбум, ОСНААУГ 31.7 тэрбум, ГУББГ 11.5 тэрбум, нийт 101.8 тэрбум төгрөг буюу нийт алдагдлын 84.4%-ийг эзэлж байна.

Харин бусад 12 ААТҮГ нь 2019-2021 онд нийт 18.8 тэрбум төгрөгийн алдалдалтай ажилласан нь нийт алдагдлын 15.6%-ийг эзэлж байгаа бөгөөд эдгээр үйлдвэрийн газруудын хэрэгжүүлж буй чиг үүргүүдийг хувийн хэвшлийн компаниудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэх боломжтой байна.

Нийслэлийн төсвөөс 2019-2021 онд санхүүжилт авч, дүрмийн санг босгосон, үйл ажиллагаандаа зарцуулсан байгууллагуудаас аудитын түүвэрт хамрагдсан 2 ХХК, 2 ХК хамрагдсан бөгөөд тухайн байгууллагуудын авсан санхүүжилтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- о Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК нь 2019-2021 онд нийт 1,291.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.
- о Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК нь 2019-2021 онд нийт 9,800.0 сая төгрөгийн дүрмийн сан, санхүүжилтийг авч ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК, Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК-ийн хэлбэрийг өөрчилж, төсөвт байгууллага болгосноор удирдлагын зардлыг бууруулах боломжтой байна.

- о Нийслэлийн орон сууцны корпорац ХК нь 2019-2021 онд 10,503.0 сая төгрөгийг түрээсийн хүүгийн төлбөрт, 350.0 сая төгрөгийн санхүүжилт, нийт 10,853.0 сая төгрөгийг нийслэлийн төсвөөс авсан байна.
- о Олон улсын худалдаа логистикийн төв ХК нь 2019-2021 онд 522.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

НОСК ХК, Олон улсын худалдаа логистикийн төв ХК-д үүссэн өр, төлбөрийн асуудлыг шийдвэрлэж, компанийг өрийн дарамтаас гаргаж, ХК нь өөрийн орлогоор өөрийгөө санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Аудитын түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ийн хог тээвэр, тохижилт үйлчилгээг 2019-2021 онд эрхэлсэн байгууллагуудаас БГД-т 1 ОНӨААТҮГ, БЗД-т 4 ОНӨААТҮГ, СХД-т 2 ОНӨААТҮГ, СБД-т 2 ОӨААТҮГ, 1 ХХК /гэрээгээр/, ХУД-т 4 ОНӨААТҮГ, ЧД-т 1 ХХК /гэрээгээр/ үйл ажиллагаа явуулсан байна.

Дээрх байгууллагуудаас БЗД-ийн 4 ОНӨААТҮГ, СХД-ийн 2 ОНӨААТҮГ, СБД-ийн 2 ОНӨААТҮГ, ХУД-ийн 4 ОНӨААТҮГ-уудыг нэгтгэн зохион байгуулснаар удирдлагын зардлыг бууруулж, үр ашгийг дээшлүүлэх боломжтой байна.

Дүгнэлт: Үйл ажиллагааны зардлыг оновчгүй төлөвлөж, арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

2.4.3. Төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тооцсон уу?

Үйлдвэрийн газрууд нь хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг тооцохдоо өмнөх оноос хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тухайн онд хэрэгжүүлэх ажлын судалгааг холбогдох мэргэжлийн хэлтсүүдээс авч, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай ажил үйлчилгээ, бараа материалын жагсаалтыг өөрсдийн орлогын зорилтод тулгуурлан гаргадаг байна.

Нийслэлийн өмчит ОСНААУГ, УСУГ, ГУББГ-ууд нь нийслэлийн хэмжээний дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны хоолой, төв цэвэрлэх байгууламж, үерийн усны далан шуудуу, авто замын ус зайлуулах хоолой зэрэг Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудыг хариуцдаг бөгөөд тухай байгууллагуудын төлөвлөсөн хөрөнгө оруулалтыг санхүүгийн хүндрэлээс шалтгаалан бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна.

Улаанбаатар хотын ус дулаан дамжуулах, цэвэр бохир ус түгээх, татах, нийтийн тээврийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, үерийн ус зайлуулах, зам, гудамж талбайг цэвэрлэх зэрэг нийтийн аж ахуйн үйлчилгээг үзүүлж буй ОНӨААТҮГ-уудын орлогыг бүрдүүлж буй үнэ, тариф нь шинэчлэгдээгүй, зах зээлийн үнээс доогуур байдгаас хамаарч гарсан зардлаа нөхөж чаддаггүй, хөрөнгө санхүүгээс шалтгаалж их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж чаддаггүй, шугам хоолой, машин, тоног төхөөрөмжийг шаардлагатай хэмжээнд шинэчилж чадаагүйгээс элэгдлийн зардал өндөр, зарим сэлбэг хэрэгсэл худалдаанд гарахаа больсон зэргээс шалтгаалж байна.

Аудитын түүвэрт хамрагдсан төвийн 6 дүүрэг болон НД-ээс СБД, ХУД-ийн зарим орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь хөрөнгө оруулалтын дүнг тухайн жилийн зорилтот түвшинд тусгаж дүүргийн ИТХ-аас баталсан холбогдох журмын дагуу батлуулсан байна.

Нийслэлийн өмчит ААТҮГ-ын 2019-2021 онд батлагдсан зорилтот түвшний нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг авч үзвэл 2019 онд 6,458.0 сая, 2020 онд 6,744.4 сая, 2021 онд 8,098.0 сая төгрөгөөр буурсан байгаа нь хөрөнгө оруулалтын эх үүсвэр болох өөрийн орлого буурсантай холбоотой байна.

Хүснэгт 27. 2019-2021 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

№	ОНӨААТҮГ-ын нэрс	Хөрөнгө оруулалт									/сая.төг/
		2019 оны зорилт	2019 оны гүйцэтгэл	2019 оны зөрүү	2020 оны зорилт	2020 оны гүйцэтгэл	2020 оны зөрүү	2021 оны зорилт	2021 оны гүйцэтгэл	2021 оны зөрүү	
1	ОСНААУГ	5,081.60	4,234.60	-847	5,852.70	5,023.80	-828.9	6,138.60	6,138.60	-	-
2	УСУГ	13,228.80	9,015.60	-4,213.20	11,827.80	8,896.70	-2,931.10	11,142.20	5,415.60	-5,726.60	-
3	Зорчигч тээврийн нэгтгэл	833.6	221	-612.6	962	-	-962	1,134.20	15.9	-1,118.30	-
4	УБЗЗАГ	580	319.1	-260.9	734.2	12.1	-722.1	636.8	80.9	-555.9	-
5	Хот тохижилтын газар	10	10	-	328.3	333.1	4.8	62.2	62.2	-	-
6	Зорчигч тээвэр гурав	541.6	541.6	-	846.6	145	-701.6	330	-	-330	-
7	Өсвөр үе хүнс	14.6	14.8	0.2	116.5	4.8	-111.7	59.9	2.6	-57.3	-
8	Хүнс хангамж төв	47.1	20.6	-26.6	73.9	3.7	-70.2	-	-	-	-
9	Багачууд хүнс	30.6	24.3	-6.3	24.9	-	-24.9	15	-	-15	-
10	Асгат	105	-	-105	-	-	-	-	-	-	-
11	ГУББГ	189	70	-119	168.2	111.3	-56.9	114.4	73.4	-41	-
12	Хөрөнгө оруулалтын газар	235.7	100.7	-135	164.9	167.5	2.6	164.9	26.9	-138	-
13	ХИХУГ	10	-	-10	166	-	-166	-	-	-	-
14	ХТСИ	76.9	5.5	-71.3	38.5	25.7	-12.8	46.9	25.9	-21	-
15	Гэрлэх ёслолын ордон	128.3	77.1	-51.2	353.9	190.2	-163.7	95	-	-95	-
Нийт дүн		21,112.90	14,654.90	-6,458.00	21,658.40	14,914.00	-6,744.40	19,940.00	11,842.00	-8,098.00	-

Орон нутгийн үйлдвэрийн газрууд нь шаардлагатай хөрөнгө оруулалтын судалгааг тооцоо судалгааны хамтаар 3Д нарт хүргүүлдэг ч санхүүгийн нөөц бололцооноос хамаарч буурч батлагддаг байна.

Харин зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, ХХК, ХК-д төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтыг гэрээгээр ажил гүйцэтгүүлэх, дүрмийн санг нэмэх зэргээр олгосон байна. Үүнд:

- 2020 онд Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-ын зорилтот тусгагдаагүй “Хонхтой цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалт, арчилгааны санхүүжилт” ажлын гүйцэтгэлд 3,426.3 сая төгрөг олгосон
- 2019 онд Улаанбаатар спорт менежмент ХК-ийн дүрмийн санд 5,000.0 сая төгрөг олгосон
- 2019 онд Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК-ийн дүрмийн санд 5,000.0 сая төгрөг олгосон
- 2020 онд Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК-ийн дүрмийн санд 4,500.0 сая төгрөг олгосон
- 2021 онд Улаанбаатар спорт менежмент ХК-ийн дүрмийн санд 1,500.0 сая төгрөг олгосон байна.

Иймд орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон ХК, ХХК-д төлөвлөсөн, хэрэгцээ шаардлага нь бүрэн тодорхойлогдсон, хүрэх үр дүн нь ойлгомжтой ажил, үйлчилгээнд санхүүжилтийг олгож, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Дулааны шугам сүлжээ, цэвэр бохир усны хоолой, төв цэвэрлэх байгууламж, үерийн усны далан шуудуу, авто замын ус зайлуулах хоолой зэрэг асуудлуудын төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалт гардгаас хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тухайн бүр тооцох боломжгүй байдаг байна.

БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?

3.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд салбар яамнууд, СЗХ, НЗДТГ, ДИТХТ хяналт хэрэгжүүлж, санхүүгийн үйл ажиллагаанд НТАГ, НДАГ, ДДАА санхүүгийн тайланд аудит хийж, зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна.

3.1.1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт хангалттай байна уу?

Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт хангалттай эсэх асуултын хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит 6 компани, орон нутгийн өмчит 26 үйлдвэрийн газрыг хамруулсан. Үүнд:

ХХК, ХК-ийн хувьд:

- “Налайхын дулааны станц” ТӨХК-нд ЭХЯ-ны дотоод аудитын хорооноос Шилэн дансны тухай хуулийн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтаар өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн нотлох баримт байхгүй, харин 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар 13 зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулсан.
- “Налайх АЗЗА” ТӨХК-нд Зам тээврийн хөгжлийн яамны хяналт шинжилгээ, дотоод аудитын газраас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа зөрчилд 13 зөвлөмж, Зам, тээвэр хөгжлийн яамны Улсын ахлах байцаагчийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 09-01/01 тоот төлбөрийн акт, 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 09-01/01 тоот зөрчил арилгуулах албан шаардлага тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна.
- “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК-д МУ-ын Ерөнхий сайдын 2020 оны 48 дугаар захирамжийг үндэслэн ЗГХЭГ-даргын 2020 оны 66 дугаар тушаалаар байгуулагдсан ЗГХЭГ, СЯ, БХБЯ, БХЯ, НЗДТГ, Хөгжлийн банкны хамтарсан ажлын хэсэг 2015-2020 оны 06-р сарын 30-ны хүртэлх хугацааны үйл ажиллагааг хамруулан хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар дараах үйл ажиллагааг хамруулжээ. Үүнд:
 - Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, ашгийн байдал,
 - Худалдан авалттай холбоотой үйл ажиллагаа
 - Батлагдсан зорилтот түвшин түүний зарцуулалт, өөрийн орлогын төлөвлөгөө, биелэлтийн байдал
 - Хариуцан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, төрийн өмчийн түрээсийн орон сууцыг ашиглах, түр суурьшуулах, түрээслэх, түрээслэн өмчлүүлэх үйл ажиллагаа
 - Хөгжлийн банканд төлөх зээлийн эргэн төлөлтийн явц
 - Байгууллагуудын болон түрээсийн орон сууцны өр, авлагын байдал

Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах 7 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Монгол Банкны 2021 оны А-1/1082 тоот албан бичгээр “Нийслэлийн орон сууцны корпорац” хаалттай ХК /НОСК ХХК/, түүний үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компани /ТЗК/-уудын үнэт цаасны эргэн төлөлтөд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлгэх хүсэлт ирүүлсний дагуу СЗХ холбогдох хууль журмын хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж

байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах 5 зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

- “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК /ХОМК/-ийн хөрөнгө оруулалтын сангуудын 2018-2020 оны үйл ажиллагаанд СЗХ-оос шалгалт хийсэн байна. Үүнд:
 - Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, СЗХ-ны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, Хорооны 2014 оны 436 дугаар тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”, Хорооны 2016 оны 198 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогчийг бүртгэх журам”-ын дагуу ажиллаж байгаа эсэхэд шалгалт хийсэн байна.
 - Дээрх шалгалтаар хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирддаг “Нийслэлийн хөгжлийн сан” хувийн ХОС, “Нийслэлийн ногоон сан” хувийн ХОС-ын үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулахаар СЗХ-ны Улсын байцаагчийн 2021 оны 186 дугаар бүхий 1 албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулсан.
- Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагаанд холбогдох төрийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн өмчит газрууд:

Аудитын түүвэрт нийт 26 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад төрийн байгууллагуудын хяналт хангалттай хэмжээнд хэрэгжиж байгааг шалгасан. Үүнд:

- НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу нийслэлийн орон нутгийн өмчит төсөвт байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн байна. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг дүгнэж байгаа шалгуур үзүүлэлтээр буюу ихэнх үзүүлэлтийг төсөөтэй байдлаар авч үзэж дүгнэх нь учир дутагдалтай байна. Дээрх байгууллагуудын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу санхүүгийн төлөвлөгөө буюу контрактаар хүлээсэн үүргийн хэрэгжилтээр дүгнэх нь зүйтэй. Нийслэлийн өмчит байгууллагуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн дүнг 2019-2020 онд баталгаажуулаагүй, 2021 оны үйл ажиллагааг үнэлж дүгнэсэн боловч ажлын хэсгийн дүнг харгалзаагүй баталгаажуулсан. НЗД-ын захирамжаар томилогдсон үнэлгээний ажлын хэсгийн үнэлгээг НЗД-ын захирамжаар баталгаажуулах, зөвлөмж чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавих ажил холбогдох хэлтэс, ажлын хэсгийн уялдаа холбоогүйгээс хангалтгүй байна.
- НИТХТ-ийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 6.1²⁰, 6.4²¹-д заасны дагуу НӨХГ-аас холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулж ажилласан нотлох баримт байхгүй байна.
- Дүүргүүдэд харьяалагдах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд ХУД-ийн ИТХ-аас 2022 онд 1 удаа хяналт хэрэгжүүлсэн, бусад төрийн байгууллагуудаас /НЗДТГ, НӨХГ, ДЗТГ, ДИТХ/ хяналт хийгээгүй байна.

²⁰“НӨХГ нь нийслэлийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд дангаараа болон холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалт хийж болно”

²¹“Энэ журмын 6.1-д заасан хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах үйл ӨХГ хяналт тавина”.

Дүгнэлт: Төрийн болон орон өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Харин дүүргүүдийн хувьд хяналт хангалтгүй байна.

3.1.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна уу?

Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд НТАГ, Нийслэлийн дотоод аудитын албанаас аудит хийж дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллажээ.

Түүвэрт хамрагдсан 30 орон нутгийн өмчит байгууллагуудад НТАГ-аас 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт 2019-2021 нийт 722.4 сая төгрөгийн 45 төлбөрийн акт тогтоосноос 569.2 сая төгрөгийг дутуу барагдуулсан, дээрх онуудад нийт 15,995.3 сая төгрөгийн зөрчилд 92 албан шаардлага өгснөөс 3,621.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаагүй, нийт 38,440.3 сая төгрөгийн 265 чиглэлийн зөвлөмж өгч биелэлт нь 89%-тай байна.

Хүснэгт 28. НТАГ-аас хийсэн санхүүгийн аудитаар өгсөн үүргийн биелэлт /2019-2021 он/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэл хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	265	38,440.0	29	8,472.5	89.1
Албан шаардлага	92	15,995.3	26	12,373.5	71.7
Төлбөрийн акт	45	722.4	14	153.2	66.6
Нийт	402	55,157.7	69	20,999.2	75.8

Мөн Нийслэлийн дотоод аудитын албанаас түүвэрт хамрагдсан дээрх газруудын 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна. Тус шалгалтаар нийт 4,243.6 сая төгрөгийн зөрчил ирлүүлж, хэрэгжилт 73.0%-тай байна.

Дүгнэлт: Төрийн байгууллагуудаас орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлсэн ч үүрэг даалгаврыг дутуу биелүүлсэн байна.

3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна уу?

Аудитын түүвэрт ТӨХК 2, орон нутгийн өмчит ХХК 2, ХК 2, ОНӨААТҮГ 23, ОНӨТҮГ 1 нийт 30 газрыг хамруулан ТУЗ, УЗ, дотоод аудитын хороо, эрсдэлийн удирдлага, гүйцэтгэх удирдлагын хяналт үр нөлөөтэй хэрэгжсэн эсэхийг шалгахад хууль тогтоомжийг мөрдөөгүй, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, хяналт шалгалт үр нөлөө муутай байна.

3.2.1. ТУЗ-ын дэргэдэх дотоод аудит, эрсдэлийн удирдлага үр нөлөөтэй байна уу?

“Налайхын дулааны станц” ТӨХК, “Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” ҮЦК ХХК, “Олон улсын логистик худалдааны төв” ХК нь 2019-2021 онд ТУЗ-ын дэргэдэх дотоод аудитын хорооноос хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент” ҮЦК ХХК. НИТХТ-ийн 2019 оны 72 дугаар тогтоолоор “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг баталж, Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн

дүрэмд заасны дагуу компанийн ТУЗ нь аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын гэсэн 3 хороотойгоор хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллаж байна.

Аудитын хороо нь 2019-2021 онд компанийн Дотоод хяналтын албыг удирдлагаар хангаж, хяналт шалгалтын ажлын удирдамжийг батлан, үүрэг даалгавар, чиглэл өгч ажилласан байна.

Хяналт шалгалтын ажил нь компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх, компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт өгөх, сайжруулахад чиглэгдсэн байна. Аудитын хороо, Дотоод хяналтын албаны жилийн ажлын төлөвлөгөө, шалгалтын ажлын тайлантай танилцан, санал зөвлөмж өгч ажиллаж ирсэн байна.

- “Налайхын дулааны станц” ТӨХК-ийн ТУЗ нь компанийн дүрмийн 7.3 дахь заалтын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж, Хувьцаа эзэмшигчдийнхээ хурлаар үйл ажиллагаагаа үнэлүүлж, өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.
- “Олон улсын логистик худалдааны төв” ХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 81.4, 81.4.1 заалтыг мөрдөж, компанийн дүрмийн дагуу хяналт хэрэгжүүлсэн байна.

Харин дараах газруудын ТУЗ, УЗ хяналт хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- “Налайх АЗЗА ТӨХК” Компанийн тухай хуулийн 81.4, 81.4.1 заалт, ТӨХ-ны 2014 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Налайх АЗЗА ТӨХК”-ийн дүрэм-ийн 10.3-10.4 дэх заалтын дагуу ТУЗ-ын дэргэдэх аудитын хорооноос 2019-2021 онд хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.
- “Нийслэлийн орон сууцны корпорац” ХК Компанийн тухай хуулийн 81.4²², 81.4.1²³ НИТХТ-ийн 2014 оны 54-р тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн ТУЗ-ийн ажиллах журмын 3.13, НИТХТ-ийн 2018 оны 51 тогтоолоор батлагдсан компанийн дүрмийн 15.1, 11.1.1-д заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй;
- “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК нь дүрэм”-ийн 10.6.3, 13.1 заалтын дагуу хяналт хэрэгжүүлээгүй;
- “Цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ: УЗ нь 2019, 2020, 2021 онд журмын дагуу ажил зохион байгуулж, үнэлж дүгнээгүй;
- “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын УЗ 2019, 2020 онд тус газрын үйл ажиллагаанд журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй;
- “Баянзүрх дүүргийн НҮГ1, НҮГ2, НҮГ3, НҮГ4”: НИТХТ-ийн 2019 оны 02-р сарын 21-ний өдрийн А/13 тогтоолоор Дүүргийн орон нутгийн үйлдвэрийн газар НҮГ-1, НҮГ-2, НҮГ-3, НҮГ-4-ийг татан буулгажээ. Тус тогтоолыг дүүргийн ЗД хэрэгжүүлж ажиллаагүй. 2019-2021 онд хяналт хэрэгжүүлээгүй;
- “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ: УЗ 2020 онд журмын дагуу ажил зохион байгуулж, үнэлж дүгнээгүй. Үүнд, Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалт, ашигт ажиллагааны түвшин сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүн, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн үнэлэлт дүгнэлт байхгүй. Сонгуультай холбогдуулан ирц бүрдээгүйгээс хуралдаагүй;

²²Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:.

²³81.4.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

- "Хот тохижилтын газар" "ОНӨААТҮГ: УЗ 2019, 2020 онд тус газрын үйл ажиллагаанд журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй;
- "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ: 2019-2021 онд хяналт хэрэгжээгүй;
- "ЧД-ийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төв" ОНӨТҮГ: ИТХТ-ийн журам болон ДИТХТ-ийн 2014 оны А/145 тогтоолоор батлагдсан журам-ын дагуу УЗ байгуулаагүй;
- "СХД-ийн Тээвэр үйлчилгээний төв" ОНӨААТҮГ: Журмын дагуу дотоод хяналт шалгалтыг 2021 онд зохион байгуулаагүй;
- "СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ" ОНӨААТҮГ: 2019, 2020 онд тус газрын үйл ажиллагаанд журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.
- "Баянгол Шинэ Өргөө" ОНӨААТҮГ-ын УЗ байгуулагдаагүй, 2019-2021 онд хяналт хэрэгжээгүй;
- Чандмань налайх ОНӨААТҮГ: УЗ байгуулаагүй, хяналт хэрэгжээгүй;
- Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ хяналт хэрэгжүүлээгүй
- Гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ УЗ байгуулаагүй, хяналт хэрэгжээгүй;
- Налайх цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ УЗ байгуулаагүй, хяналт хэрэгжээгүй байна.

Дүгнэлт: ТУЗ, УЗ, аудитын хорооноос төрийн болон орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

3.2.2. Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хангалттай байна уу?

"Налайхын дулааны станц" ТӨХК, "Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент" ҮЦК ХХК нь 2019-2021 онд гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод аудитын хорооноос хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- "Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент" ҮЦК. Дотоод хяналтын алба нь аудитын хорооноос өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг шалгалтын удирдамжид тусган компани болон түүний удирдаж буй сангуудад хяналт шалгалт хийж зөрчил дутагдлыг илрүүлж, санал зөвлөмж өгч шалгалтын тайланг Гүйцэтгэх удирдлага болон Аудитын хороонд хүргүүлж, биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажилласан байна.
- "Налайхын дулааны станц" ТӨХК ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", Гүйцэтгэх захирлын 2018 оны А/14 дүгээр тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу хяналт хэрэгжүүлсэн байна.

Харин дараах газрууд хяналт хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Налайх АЗЗА ТӨХК үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг 2019-2020 онд зохион байгуулж ажиллаагүй;
- Нийслэлийн орон сууцны корпорац ХК. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналт шалгалтыг 2019, 2020, 2021 онд зохион байгуулаагүй, НИТХТ-ийн 2018 оны 51 тогтоолоор батлагдсан компанийн дүрмийн 8.5.2, 8.5.12 заалт мөрдөж ажиллаагүй;
- Улаанбаатар хотын хөгжлийн корпорац НӨХК. Дотоод хяналт шалгалтыг 2019, 2020, 2021 онд зохион байгуулаагүй;

- Олон улсын логистик худалдааны төв ХК. Дотоод хяналт шалгалтыг 2019, 2020, 2021 онд зохион байгуулаагүй.
- "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ: Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтыг 2019, 2020 онд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- Цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ: Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтыг 2019, 2020 онд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй;
- Баянзүрх дүүргийн НҮГ1, НҮГ2, НҮГ3, НҮГ4: ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам", ААНБ-ын дотоод журам-ын 2.6.2-д ОНӨААТҮГ-ын дарга холбогдох дүрэм журам боловсруулан, батлах, мөрдүүлэх, хяналт тавьж ажиллана. Гүйцэтгэх удирдлагаас 2019-2021 онд хяналт хэрэгжүүлсэн нотлох баримт байхгүй;
- Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ: Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт 2019, 2021 онд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй;
- ЧД-ийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих бизнес инкубатор төв ОНӨТҮГ: ДИТХТ-ийн 2011 оны 94 тогтоолоор баталсан дүрмийн 5.8.10-д ЧД-ийн БИТ-д бойжигчдын ажлын чанар, эрүүл ахуй хөдөлмөр хамгааллын шаардлагад хяналт шаардлага тавих гэсэн заалт орсон, дүрэмд тусгагдаагүй, хяналт тавих ажил хийгдээгүй;
- СХД-ийн Тээвэр үйлчилгээний төв ОНӨААТҮГ: Журмын дагуу дотоод хяналт шалгалтыг 2019, 2020 онд зохион байгуулаагүй;
- СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ: Журмын дагуу дотоод хяналт шалгалтыг 2021 онд зохион байгуулаагүй;
- Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ: Журмын дагуу дотоод хяналт шалгалтыг 2019-2020 онд зохион байгуулаагүй;
- Чандмань налайх ОНӨААТҮГ: ДИТХТ-ийн 2015 оны 22 тогтоолоор батлагдсан дүрмийн 7.1-д заасан заалт, дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй;
- Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ: НДИТХТ-ийн 2015 оны 14 тогтоолоор батлагдсан дүрмийн 4.7-д дах заалтын дагуу дотоод хяналт шалгалт зохион байгуулаагүй;
- Налайх Гэрэлтүүлэг чимэглэлийн алба ОНӨААТҮГ: 2019 онд дотоод хяналт хэрэгжүүлээгүй;
Налайх цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ: Журмын дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт: Зарим төрийн болон орон нутгийн өмчит газруудын гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод аудитын нэгжгүй, нэгжтэй ч үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна уу?

Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаагүйгээс орон нутгийн өмчит хуулийн этгээдийн судалгаа, тайлан мэдээ зөрүүтэй, шилэн данстай холбоотой мэдээллийг ил тод, нээлттэй олон нийтэд хүргэж байгаа ч хуулийн этгээд бүрээр авч үзэхэд хэрэгжилт харилцан адилгүй байгаа нь мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж чадахгүй байна.

3.3.1. Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаатай байна уу?

Төрийн байгууллагуудын тайлан мэдээлэл уялдаатай эсэхийг түүвэрт хамрагдсан 30 газрыг хамруулан шалгахад мэдээ, судалгаа, тайлан харилцан адилгүй байна. Тухайлбал:

- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүртгэл, үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй;
- НЗДТГ, НӨХГ-т дүүргийн харьяа орон нутгийн өмчит байгууллагын мэдээлэл, судалгаа, нэгдсэн мэдээллийн бааз шинэчлэлт хийгдээгүй;
- Холбогдох байгууллагуудын хамтарсан хяналт шалгалтын дүн мэдээ, тайланг харьяа байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох ажил хангалтгүй;
- НЗДТГ болон НӨХГ-т нийслэл, дүүргийн харьяа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь холбогдох тайлан мэдээг харилцан солилцож өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрддөггүй, захирлын тушаал, удирдах зөвлөлийн шийдвэр зэргийг мэдээлдэггүй;
- НИТХ-ын тогтоол шийдвэрийг дүүргийн харьяа газрууд хэрхэн хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зохистой түвшинд хэрэгжихгүй байна.

Мөн аудитад шаардагдах орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой нэгдсэн судалгааг НЗДТГ, НӨХГ, дүүргийн ЗДТГ-аас авсан. Гэтэл дээрх судалгаа мэдээлэл, орон нутгийн өмчит хуулийн этгээд тус бүрээс ирүүлсэн судалгаа мэдээлэл хоорондоо зөрүүтэй нь нэгтгэхэд хүндрэл бэрхшээл үүсгэж байна. Энэ нь орон нутгийн өмчит хуулийн этгээд болон төрийн байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт: Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаагүйгээс орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээ, судалгаа, тайлан мэдээ зөрүүтэй байна.

3.3.2. Төрийн өмчийн хуулийн этгээдийн мэдээлэл ил тод, нээлттэй байна уу?

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль /2021.12.17-нд хүчингүй болсон/, Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүд нь иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангаж, өмч хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ ил тод, нээлттэй байх үүрэг хүлээсэн.

Аудитын түүвэрт хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит 30 газар нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ үндсэн үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв, санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, хууль тогтоомжийг мөрдсөн эсэхийг шалгахад 13 нь буюу 40.6% нь цахим хуудсаараа дамжуулан дээрх төрлийн мэдээллүүдийг ил тод мэдээлсэн байна.

Харин Налайх АЗЗА ХК, Гэрлэх ёслолын ордон болон дүүргүүдийн орон нутгийн өмчит 17 газар өөрсдийн цахим хуудасгүй, харьяа дээд шатны байгууллагуудын цахим хуудас болон Facebook хуудсанд байгууллагын танилцуулгыг байршуулсан байна. Хавсралт 7

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд хууль, журамд заасны дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж, холбогдох мэдээллийг тодорхой хугацаанд мэдээлэх үүрэгтэй.

Аудитын хамрах хугацаа буюу 2019-2021 онд төрийн болон орон нутгийн өмчит 24 газрууд нийт 22565 мэдээллийг байршуулахаар байна. Үүнээс 19872 мэдээлэл буюу 76.4%-ийг мэдээлсэн, 2693 буюу 23.6%-ийг дутуу мэдээлсэн байна.

Хүснэгт 29. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын мэдээлсэн тоо

№	Нэр	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээлсэн байдал /хувиар/
1	БГД Шинэ өргөө ОНӨААТҮГ	449	348	77.5
2	БЗД НҮГ 1 ОНӨААТҮГ	427	316	74
3	БЗД НҮГ 2 ОНӨААТҮГ	392	248	63.3
4	БЗД НҮГ 3 ОНӨААТҮГ	390	368	94.4
5	БЗД НҮГ 4 ОНӨААТҮГ	399	377	94.5
6	Геодизи УББГ ОНӨААТҮГ	357	175	49
7	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ	322	259	80.4
8	ЖДҮ дэмжих төв ЧД ОНӨААТҮГ	207	179	86.5
9	Зорчих тээвэр нэгтгэл ОНӨААТҮГ	398	252	63.3
10	Налайх Цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ	342	302	88.3
11	Налайх Гэрэлтүүлэг ОНӨААТҮГ	319	221	69.3
12	Налайх тохижилт ОНӨААТҮГ	256	214	83.6
13	Налайх Чандмань ОНӨААТҮГ	434	335	77.2
14	ОСНААУГ ОНӨААТҮГ	11885	11461	96.4
15	СБ Дэвшил менежент ОНӨААТҮГ	28	9	32.1
16	СБ Дэвшил ОНӨААТҮГ	490	279	56.9
17	СХД Тохижилт ОНӨААТҮГ	394	305	77.4
18	СХД Тээвэрлэлт ОНӨААТҮГ	364	295	81
19	УБЗЗАГ ОНӨААТҮГ	795	202	25.4
20	УСУГ ОНӨААТҮГ	1697	1666	98.2
21	ҮЦХүрээлэн ОНӨТҮГ	447	408	91.3
22	Хот тохижилт ОНӨААТҮГ	1080	1041	96.4
23	ХУД АГРО ОНӨААТҮГ	374	308	82.4
24	ХУД тохижилт ОНӨААТҮГ	319	304	95.3
Нийт		22565	19872	76.4


Хувьцаат компаниуд:

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниуд нийт 2361 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсан байршуулахаар байна. Үүнээс 1779 мэдээлэл буюу 75.3%-ийг мэдээлсэн, 582 буюу 24.6%-ийг дутуу мэдээлсэн.

Хүснэгт 30. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын мэдээлсэн тоо

№	Нэр	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээлсэн байдал /хувиар/
1	Нийслэлийн орон сууц корпораци ХК	504	448	88.9
2	ОУХ Логистик ХК	434	190	43.8
3	УБХ Корпораци ХК	238	183	76.9
4	УБХОМ ХК	339	218	64.3
5	Налайхын дулааны станц ТӨХК	465	465	100
6	Налайх АЗЗА	381	275	72.2
Нийт		2361	1779	

Дүрслэл 1. Шилэн дансны хэрэгжилт



Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь 2019 онд 90.4%, 2020 онд 71.4% байсан бол 2021 онд нийт мэдээллийн 88.6%-ийг мэдээлсэн байна. Энэ нь ОНӨААТҮГ-уудын нэгдсэн цахим хуудсанд хамрагдах, мэдээлэл байршуулах үүргийн хэрэгжилт 2020, 2021 оныг 2019 онтой харьцуулахад мэдээллийг ил тод

байршуулах үзүүлэлт нь буурч, хууль тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
Хавсралт 8

Дүгнэлт: Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдүүд мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байгаа ч хуулийн этгээд бүрээр авч үзэхэд хэрэгжилт харилцан адилгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн аудитын түүвэрт хамрагдсан 30 газрын хүрээнд дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн түвшинд хууль тогтоомжийн хэрэгжилт харилцан адилгүй, үйл ажиллагааны онцлог, чиглэл, хамрах хүрээ зэрэгтэй холбоотой хүндрэл, бэрхшээл, тулгамдсан асуудал үүсэх, эрх бүхий байгууллагуудын ажлын уялдаа холбоо дутмагаас шалтгаалж үйл ажиллагаа зохистой түвшинд хэрэгжихгүй байна.
2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх зарчим, аргачлалд орон нутгийн түвшинд мөрдөх зохицуулалт тусгагдаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.
3. ОНӨААТҮГ-ын УЗ-ын тогтоол, биелэлттэй холбоотой тайлан мэдээг заасан хугацаанд НӨХГ-т хүргүүлдэггүйгээс шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, НИТХТ-дэд тайлагнах ажил хангалтгүй байна.
4. Нийслэлийн өмчит ХК, ХХК-иуд сүүлийн 3 жилд их хэмжээний өртэй, ашиггүй байгаа нь хуулийн этгээдийн хувь эзэмшлийг хэрэгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага /НИТХ/-аас авч хэрэгжүүлж буй бодлого, ТУЗ-аас гаргасан шийдвэр үр нөлөөгүй байна.
5. Нийслэлийн орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь тухайн жилийн зорилтот түвшнийг төлөвлөхдөө тухайн шатны ИТХ-ын тогтоолоор баталсан журмын хүрээнд өмнөх оны гүйцэтгэл, цалин норм, норматив үйлчилгээний үнэ, тарифыг баталсан шийдвэр, салбарын статистик мэдээллийг үндэслэн боловсруулсан байна.
6. Дүүргүүдийн зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан гэрээнд эдийн засгийн үр ашгийн нэмэгдүүлэх зорилтыг тодорхой тусгахгүй байгаа нь төрөөс баримталж буй үйлдвэрийн газруудын зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх бодлоготой нийцэхгүй байна.
7. Зарим дүүргийн ОНӨААТҮГ эрх зүйн баримт бичиг болох журмууд тухайн дүүрэгт батлагдаагүй, эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг боловсруулаагүй байна.
8. Үнэ тарифын зохицуулалттай холбоотойгоор нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газрууд нь орлогоороо зардлаа нөхөж чадахгүй, их хэмжээний алдагдал хүлээсээр байна.
9. Аудитын түүвэрт хамрагдсан 30 орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь 2021 оны жилийн эцсийн байдлаар 1,407,8 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 290.1 тэрбум төгрөгийн орлого олж, 323.0 тэрбум төгрөгийн зардал 6.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, 86.7 тэрбум сая төгрөгийн өр 235.2 тэрбум төгрөгийн авлагатай байна.
10. Төрийн байгууллагуудаас орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа болон санхүүд хяналт, шалгалт хэрэгжүүлсэн ч үүрэг даалгаврыг биелэлт хангалтгүй байна.
11. Төрийн болон орон нутгийн өмчит газруудын ТУЗ, УЗ болон гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт хангалтгүй байна.
12. Төрийн байгууллагуудын мэдээлэл уялдаагүйгээс орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээ тайлан, судалгаа зөрүүтэй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх зарчим, аргачлалд орон нутгийн түвшинд мөрдөх зохицуулалт бий болгох талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
2. ОНӨААТҮГ, ТУЗ, УЗ-ын үйл ажиллагаа, ИТХ-аас гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх;
3. Дүүргийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний үлгэрчилсэн журмыг батлах;
4. Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газруудын их хэмжээний алдагдал хүлээж буй асуудлыг судалж, үүссэн өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээ авах.

Нийслэл, дүүргийн Засаг дарга нарт:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ТУЗ, УЗ-д мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах арга хэмжээ авах;
2. Орон нутгийн өмчийн талаар төрийн эрх бүхий байгууллага, нийслэл, дүүргийн ИТХ-аас авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг хангуулах; Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай журмын хүрээнд контракт байгуулж, зорилтот түвшнийг бүрэн тусгаж, үйлдвэрийн газруудын зардлыг бууруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, үр нөлөөг дээшлүүлэх;
3. Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газрууд нь орлогоороо зардлаа нөхөж чадахгүй, их хэмжээний алдагдал хүлээж буй асуудлыг судалж, шийдвэрлэх талаар арга хэмжээ авах;
4. Төрийн болон орон нутгийн өмчит газрууд, ТУЗ, УЗ болон гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт хангалтыг сайжруулах, ИТХ, ЗД-аас гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх;
5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн талаарх судалгаа, тайлан мэдээний зөрүүтэй байдлыг арилгаж, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, хууль тогтоомжийг бүрэн мөрдүүлэх;
6. Харьяа орон нутгийн өмчит газруудын хөрөнгө санхүү болон үйл ажиллагааг нэгдсэн удирдлага арга зүйгээр ханган, хяналт тавьж үр дүнг НТАГ-т 2023 оны 10 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх;

Нийслэлийн өмчийн харилцааны газарт

1. Дүүргүүдийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг хууль тогтоомжийн хүрээнд контракт байгуулж-зорилтот түвшнийг тусгах, зардлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар мэргэжил арга зүйгээр хангах;
2. Төрийн болон орон нутгийн өмчит газрууд, ТУЗ, УЗ болон гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтыг сайжруулах, ИТХ, ЗД-аас гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж;
3. Компаниудаар эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтлүүлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах ажлыг зохион байгуулах;

4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн талаарх судалгаа, тайлан мэдээний зөрүүтэй байдлыг арилгаж, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, хууль тогтоомжийг бүрэн мөрдүүлэх;

Холбогдох байгууллагын санал

Саналд өгсөн тайлбар

Аудитын тайлангийн төсөлд санал авахаар 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 972-980 дугаар албан бичгүүдээр Нийслэл, дүүргийн Засаг дарга, НӨХГ-т хүргүүлсэн ч Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй.

НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

№	НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		Биелэлт	
	Заалтын дугаар, утга		Заалтын дугаар, утга	
1.	1.6.1	Нийслэлийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.	1.6.1	Нийслэлийн өмчит байгууллагуудаас 2016-2020 онуудад нийт 3,346 байгууллагын 52,006 нэр төрлийн 95,736 сая төгрөгийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд, 2019 онд 20,637 сая төгрөгийн хөдөлгөөн: 197 байгууллагын 5,245 сая төгрөг бүртгэхээр, шинээр худалдан авах 2,496 сая төгрөг, данснаас хасахаар 10,786 сая төгрөг, балансаас баланст 50 байгууллагын 1,867 сая төгрөг. 2020 онд 27,929 сая төгрөг: Бүртгэх-126 байгууллагын 3,365 сая, шинээр худалдан авах-1,277 сая, данснаас хасах-21,057 сая, балансаас баланст шилжүүлж 42 байгууллагын 2,230 сая төгрөгийн хөрөнгө хэмнэсэн/ Нийт хэмнэлт 12,620 сая төгрөг. - Нийслэлийн Засаг даргын захирамжаар балансаар баланст шилжүүлсэн барилга байгууламж, тээврийн хэрэгслийн нийт дүн 212,785 сая төгрөг байна. - Нийслэлийн өмч хувьчлалын бодлогыг сайжруулах ажлын хүрээнд улсын төсөвт алдагдалтай, хувьчлах шаардлагатай 27 барилга байгууламж, 1 аж ахуй нэгжийг худалдан борлуулж, нийслэлийн төсөвт 35,1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. - Ашиглалтын шаардлага хангахгүй, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүйг нь тогтоогдсон хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулж 832,5 сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн.
2.	1.6.6	Үл хөдлөх эд хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын төслийг боловсруулж хэрэгжүүлнэ.	1.6.6	Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 01, 02 дугаар албан даалгавар болон Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны зорилт, "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль", "Нийслэл хотын албан татварын тухай хууль"-ийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Дүүргийн ЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		Биелэлт	
	Заалтын дугаар, утга		Заалтын дугаар, утга	
1.	1.6.1	Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлнэ.	1.6.1	Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/713 дугаар захирамжийн дагуу газрын эрхийг үнэлж санхүүгийн тайланд тусгах, Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлэх ажил зохион байгуулж харьяа дүүргийн дахин үнэлгээнд хамрагдсан 58 байгууллага дахин үнэлгээ хийгдээгүй 21 байгууллага нийт 79 байгууллагын үнэлгээний ажлын нэгтгэлийг хийн Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн. Энэ ажлын үр дүнд өмчийн маргаантай байсан эд хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж газар, үл хөдлөх хөрөнгөө бодит үнэ цэнээр үнэлж санхүүгийн тайланд тусгасан. Дүүргийн харьяа төсвийн байгууллагуудын төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн өмч хөрөнгийн бүртгэлд тухай бүр хяналт хэрэгжүүлсэн. ЗДТГ-ын даргын 2019 оны А/66 дугаар тушаалын дагуу Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадад хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийж нэгдсэн дүнг гаргасан. Албан хаагч нартай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ хийж бүртгэлжүүлсэн. Ашиглалтын хугацаа дуусаж, эвдэрч гэмтсэн 77.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актуулахаар НӨУАГ-т санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна.
2.	1.35.1	Дүүргийн өмчийн эд	1.35.1	ДЗДТГ-ын даргын А/78 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2019 оны эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион

		хөрөнгийн үзлэг, тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулж, бүртгэлгүй болон хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг цаг тухайд нь бүрэн бүртгэлжүүлэх		байгуулсан. НӨАУГ-ын даргын 2019 оны А/134 дүгээр тушаалын дагуу нийт 126 байгууллагын "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний биелэлтийг дүгнэсэн. Тайлант хугацаанд нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар: Барилга байгууламж 771.6 сая, Тоног төхөөрөмж 272.4 сая, Нийтийн эзэмшил 823.1 сая,Тавилга 86.8 сая,Ном 1.9 сая төгрөг нийт 1.9 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна..
3.	2.1.2	Орон нутгийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх зэргээр тусгасан байна.	2.1.2	2019 он Зорилтот жилийн хүрээнд тус дүүрэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6.471.6 төгрөгийн 4 ажил, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,819.6 сая төгрөгийн 10 ажил, ОНХС-н хөрөнгө оруулалтаар 312.3 сая төгрөгийн 12 ажил, нийт 8,603.5 сая төгрөгийн 26 хөрөнгө оруулалтын ажил хийгдэж байна. 2020 онд Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 ажлын 5,164.3 сая төгрөг, ОНХС-н хөрөнгө оруулалтаар 83.9 сая төгрөгийн 2 ажил, Дүүргийн төсвийн хөрөнгөөр 33.1 сая төгрөгийн 3 ажил хийгдсэн байна. ОНХС-н хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг тухай бүр данс бүртгэлд тусган ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Хавсралт-3

НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

№	Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		Биелэлт	
	Заалтын дугаар, утга		Заалтын дугаар, утга	
1.	3.1.1.1	Нийслэлийн өмчийн хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг тогтоож, өмч ашиглалтыг эргэлтэд оруулна.	3.1.1.1	ТӨБЗГ 2022 оны төсөвт Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгохоор 1,200.00 сая төгрөгийг батлуулсан. ТӨБЗГ-ын ажлын хэсэгт НӨАУГ-ын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнийг оруулан хамтран ажиллахаар болжээ. -"Улаанбаатар лифт" ОНӨТҮГ-ыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар"-тай, -"Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ыг "Хүнс хангамж төв" ОНӨТҮГ-тай, - 4 үйлдвэрлэл технологийн паркийг нэгтгэж нэгдсэн 1 захиргаатай болгох зэрэг саналыг танилцуулсан байна. Аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газраас 2021 онд нийт 287,6 тэрбум төгрөгийн орлого олж, 355,6 тэрбум төгрөгийн зардал гарган нийт 67,9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөө ирүүлснийг хянан алдагдлын хэмжээг 18,2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 1.17 төгрөг байхаар төлөвлөсөн байна.
2.	3.1.1.2	Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани төрийн өмчит компанийн тоог бууруулна.	3.1.1.2	-"Улаанбаатар лифт" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар"-тай, -"Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг "Хүнс хангамж төв" орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай, - 4 үйлдвэрлэл технологийн паркийг нэгтгэж нэгдсэн 1 захиргаатай болгох зэрэг саналыг танилцуулсан. Аж ахуйн тооцоотой 15 үйлдвэрийн газраас 2021 онд нийт 287,6 тэрбум төгрөгийн орлого олж, 355,6

				тэрбум төгрөгийн зардал гарган нийт 67,9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөө ирүүлснийг хянан алдагдлын хэмжээг 18,2 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 1.17 төгрөг байхаар төлөвлөсөн байна.
3.	3.1.1.3	Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.	3.1.1.3	Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын төлөвлөгөө нь 2021 оны 12 сарын 28-ны өдрийн байдлаар 2.349.88 сая төгрөгийг төвлөрүүлж биелэлт 100 хувьтай байна.

Хавсралт-4

Дүүргийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилт				
№	Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		Биелэлт	
	Заалтын дугаар, утга		Заалтын дугаар, утга	
1.	1.6.1	Дүүргийн өмчид байгаа хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлнэ.		Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан боловч 2021 онд хэрэгжүүлээгүй байна.
2.	3.1.1	Нийслэл дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ.		2021 онд Нийслэл, дүүргийн өмчийн байрыг 4 аж ахуйн нэгжид зах зээлийн бодит үнэлгээг үндэслэн түрээслүүлж төсөвт 6,377.8 мян.төгрөг, ХЦС 138.0 мянга, ХААА 1,003.0 мянган төгрөг, Соёлын ордон 400.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн бөгөөд ЖДҮДТ нь Ковид-ын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсноос шалтгаалан төлөвлөгөө тасарсан байна. ЗДТГ, ЖДҮДТ-ийн ашиглагддаг талбайг иргэн, ААНБ байгууллагад түрээслүүлж, өөрийн орлогод 6,377.8 мянган төгрөг бүрдүүлсэн байна.
3.	3.1.2.	Нийслэл дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, татвар ногдуулах хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн хялбаршуулна		Улсын төсөв 510.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,131.8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 221.7 хувь биелсэн. Нийслэлийн төсөв 744.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 729.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 97.0 хувьтай. Орон нутгийн төсөв 376.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 511.0 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 135.8 хувьтай тус тус биелүүлсэн. Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь тайлант оны зорилтот түвшинд өөрийн орлогыг 30.0 сая төгрөгөөр төлөвлөн Засаг даргатай контракт гэрээ байгуулж, Захирлын тушаалаар байгууллагын машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслүүлэх тариф батлан хэрэгжүүлж байна. Жилийн эцсийн байдлаар 6 удаа тээврийн хэрэгсэл түрээсээр ажиллуулж 20.0 сая төгрөгийн өөрийн орлогыг бүрдүүлсэн. Мөн Дүүргийн төв талбайн засварын ажлын тендерт оролцож 27.6 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллажээ.Илч-Орд ОНӨААТҮГГазар нь 2021 оны жилийн эцсийн байдлаар авто машин механизмыг түрээслэн 12.5 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлж ажилласан байна. Улсын төсвийн орлогыг 553.8 сая, Нийслэлийн төсвийн орлогыг 742.0 сая , дүүргийн төсвийн орлогыг 409.5 сая төгрөгөөр төлөвлөсөн төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.
4.	3.1.3	Дүүргийн өмч, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган, удирдлагын менежментийг сайжруулж, өмч ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх	3.1.3	Орон нутгийн өмчийн ашиглалт, арчлалт хамгаалалтын хүрээнд 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн болон бараа материал эд аж ахуйн тооллогыг Тамгын газрын 2021 оны 12 сарын 01

		арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.		өдрийн А/135 тоот тушаалаар хийж гүйцэтгэсэн. Тооллогод нийт Тамгын газрын 14 тасаг, хэлтэс, 27-н хороод хамрагдсан. Тооллогоор үндсэн хөрөнгийн 113.1 тэрбум төгрөгийн 3589-н ширхэг хөрөнгө тоологдсоноос ашиглалтын хугацаа дууссан болон ашиглах боломжгүй хөрөнгийг НӨАУГ-т данс бүртгэлээс хасах буюу актлах хүсэлтээ хүргүүлсэн байна.
5.	3.1.2	Дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.		СХД-ийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан боловч 2021 онд хэрэгжээгүй байна.
6.	3.1.6	Орон нутгийн өмчийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлнэ.		СХД-ийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан боловч 2021 онд хэрэгжээгүй байна.
7.	3.1.4.1	Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулан, өмч хөрөнгийн ашиглалтад бүртгэлээр тавих хяналтыг дээшлүүлж ажиллана.	3.1.4.1	Чингэлтэй дүүргийн 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/473 дугаар захирамжаар томилогдсон хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авах Ажлын хэсэг бүтээн байгуулалтын 15 ажилд үүрэг даалгавар өгч, комиссын акт үйлдэн гэрээг дүгнэж, материал бүрдүүлэлт хийж ажилласан. 2020 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 121,3 тэрбум төгрөгийн эд хөрөнгө тооллогод хамрагдсан ба дүүргийн өмчид бүртгэлтэй нийт 61 нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай, томоохон тохижилтуудыг “Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК-д гэрээгээр хүлээлгэн өгч арчлалт, хамгаалалт, сэргээн засварлалтыг хариуцуулан тухай бүр хяналт тавин ажилласан. Дүүргийн өмчид бүртгэлтэй хог тээврийн автомашинуудыг “Чингэлтэй Тохижилт үйлчилгээ” ХХК-д гэрээгээр хүлээлгэн өгч эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээ, зориулалтын дагуух ашиглалтад нь тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Чингэлтэй дүүрэгт 2021 оны жилийн эцсийн байдлаар 1744.7 сая төгрөгийн хөрөнгийг дүүргийн өмчид бүртгэн авч ажилласан. Ашиглалтын хугацаа дууссан 87.9 сая төгрөгийн 11 ширхэг Хонда фит автомашиныг акталж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 359.4 сая төгрөгийн 3 ширхэг Мицубиши тээврийн хэрэгсэл, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 147.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг Исузу тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасаж ажилласан байна.
8.	3.1.1.1	Өмчийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулж нийтийн эзэмшлийн зам талбай, түүхэн дурсгалт хөшөө, соёлын өвийг сэргээн засах орчны тохижилтыг хийх бодлогыг хэрэгжүүлнэ	3.1.1.1	- Улсын төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн тайлант онд 550.0 сая төгрөгийн төсөвтэй 1 ажил, тайлант онд хэрэгжих 1,566.4 сая төгрөгийн төсөвтэй 4 ажил, -Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн 1,069.9 сая төгрөгийн төсөвтэй 2 ажил, тайлант онд 950,4 сая төгрөгийн 3 ажил, -Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн 470.0 сая төгрөгийн 20 ажил дууссан. Тайлант хугацаанд нийт 8,536.1 сая төгрөгийн 30 ажил бүрэн дууссанаас хөрөнгөнд бүртгэх шаардлагатай 9 хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэж авсан байна. Мөн дүүргийн хэмжээнд байгаа 68 хүүхдийн тоглоомын судалгааг гарган хөрөнгийн бүртгэлийн тулгалтыг хийсэн байна.

9.	3.1.1.2	Дүүргийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн нэгдсэн систем бий болгоно	3.1.1.2	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамжийг төсөвт байгууллагын удирдлагуудад танилцуулж, тооллого зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор Google Earth программ дээр дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийн өмчлөчийг тодорхойлж цэг тайлбар хатгах ажлыг хийж 2016 оноос хойш хийсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг бүртгэлтэй хөрөнгөтэй тулгалт хийн бүртгэлд аваагүй хөрөнгийн судалгааг гаргаж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах бэлтгэл ажил хангагдан 2021 оны санхүүгийн тайланд шаардлага хангасан эрх зүйн акттай хөрөнгийг бүртгэж авахад бэлэн болсон байна..
10.	3.1.4.2.	Дүүргийн өмч, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгч эрсдэлийн удирдлагаар ханган, зөвлөмж өгч ажиллана.	3.1.4.2	Чингэлтэй дүүргийн дотоод аудитын албанаас 2021 онд сургууль-7, сургуулийн өмнөх цэцэрлэг-13, дүүргийн дэргэдэх хэлтэс, албад-4, өрхийн эрүүл мэндийн төв-11 нийт 35 байгууллагад санхүү, нийцэл, гүйцэтгэлийн аудит, хяналт шалгалтыг хийж ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр сургууль-7, цэцэрлэг-13, дүүргийн хэлтэс, алба-11, өрхийн эрүүл мэндийн төв-11 Сангийн яамны "Хяналт шалгалт хийх тухай" нэгдсэн удирдамжаар-2, Засаг даргын баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээр хяналт шалгалт хийх удирдамжаар-59, нийт давхардсан тоогоор 103 байгууллагад санхүү, нийцэл, гүйцэтгэлийн аудит, хяналт шалгалтыг хийж ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.
11.	4.4.3	Дүүргийн орон нутгийн өмчийг бүртгэлжүүлж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ зэргээр тусгасан байна.	4.4.3	Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийж байгаа ажлуудад өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Дүүргийн 2021 оны хөрөнгө оруулалтаар 3,454.1 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж ашиглагч талд хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгуулан ажилласан. Дүүргийн хөрөнгөд бүртгэлтэй байсан 6 дугаар хороонд байрлах олон жил ашиглагдаагүй халуун усны барилгыг дүүргийн төсвийн хөрөнгөөр засварлаж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нэг цэгийн төв болгох мөн 16 дугаар хорооны халуун усны барилгыг засварлаж дүүргийн Цагдаагийн газарт ашиглуулахаар Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу ашиглалтад оруулахаар тус тус ажиллаж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна..

Хавсралт-5

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн ТУЗ, УЗ-тай эсэх мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	хэлбэр	ТУЗтай	УЗтай	ТУЗ УЗгүй
1	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
2	ГУББГ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
3	ОСНААУГ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
4	Хот тохижилт ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
5	УСУГ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
6	Зорчигч нэгтгэл ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
7	УБЗЗАГ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ		тийм	
8	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	ХК	тийм		
9	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ	ОНӨТҮГ		тийм	
10	Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ХХК	ХХК	тийм		
11	Олон улсын логистик худалдааны төв ХК	ХК	тийм		
12	НОСК ХХК	ХХК	тийм		
13	Налайх дулаан ТӨХК	ТӨХК	тийм		
14	Налайх АЗЗА ТӨХК	ТӨХК	тийм		
15	БЗД ЗДТГ НҮГ-1	ОНӨААТҮГ			тийм
16	БЗД ЗДТГ НҮГ-2	ОНӨААТҮГ			тийм
17	БЗД ЗДТГ НҮГ-3	ОНӨААТҮГ			тийм
18	БЗД ЗДТГ НҮГ-4	ОНӨААТҮГ			тийм

19	БГД ЗДТГ, Баянгол Шинэ-Өргөө ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
20	ХУД ЗДТГ, Хан Уул Агро ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	тийм		
21	ХУД ЗДТГ, Хан-Уул дүүргийн Тохижилт Үйлчилгээний Төв	ОНӨААТҮГ	тийм		
22	СХД ЗДТГ,Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	тийм		
23	СХД ЗДТГ, Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	тийм		
24	ЧД ЗДТГ, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
25	СБД ЗДТГ, Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	тийм		
26	СБД ЗДТГ,Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ	тийм		
27	НД ЗДТГ, Чандмань Налайх ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
28	НД ЗДТГ, Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
29	НД ЗДТГ, Гэрэлтүүлэг Чимэглэлийн алба ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
30	НД ЗДТГ, Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	ОНӨААТҮГ			тийм
	Нийт		12	8	10

Хавсралт - 6

Санхүүгийн тайлангийн балансын шинжилгээ

Үзүүлэлт	Тоон үзүүлэлт				Өсөлтийн хувь		
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	66,831	73,239	92,613	100,893	9.6%	26.5%	8.9%
Мөнгөн хөрөнгө	33,512	37,227	32,378	24,418	11.1%	-13.0%	-24.6%
Авлага	11,989	13,667	32,957	53,191	14.0%	141.1%	61.4%
Ажиллагчидтай холбогдсон	77	82	159	275	6.7%	94.3%	72.9%
Төлбөртэй үйлчилгээний	7,382	8,041	10,482	23,640	8.9%	30.4%	125.5%
Дансны авлага	1,647	1,754	14,856	21,961	6.5%	747.2%	47.8%
Татвар, НДШ-ын	305	200	1,112	2,356	-34.4%	455.1%	111.9%
Байгууллагаас авах	2,485	3,418	6,170	4,746	37.5%	80.5%	-23.1%
Хувь хүмүүсээс авах	93	172	177	213	85.6%	3.0%	20.1%
Урьдчилгаа	2,650	2,778	2,967	2,588	4.9%	6.8%	-12.7%
Бараа материал	18,680	19,567	24,312	20,696	4.7%	24.3%	-14.9%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	662,312	638,541	627,741	694,415	-3.6%	-1.7%	10.6%
Биет хөрөнгө нийт	537,667	513,909	502,958	568,104	-4.4%	-2.1%	13.0%
Барилга, байгууламж, орон сууц	243,591	256,374	264,290	284,357	5.2%	3.1%	7.6%
Авто-тээврийн хэрэгсэл	69,509	75,684	78,915	82,051	8.9%	4.3%	4.0%
Машин тоног төхөөрөмж	155,531	159,028	163,467	186,124	2.2%	2.8%	13.9%
Тавилга, аж ахуйн эд хогшил	3,638	4,312	5,617	5,891	18.5%	30.3%	4.9%
Бусад үндсэн хөрөнгө	238,289	243,265	249,601	311,437	2.1%	2.6%	24.8%
Хуримтлагдсан элэгдэл	(180,312)	(225,171)	(260,523)	(302,591)	24.9%	15.7%	16.1%
Дуусаагүй барилга, байгууламж	7,420	416	1,592	834	-94.4%	282.8%	-47.6%
Биет бус хөрөнгө	124,646	124,632	124,784	126,270	0.0%	0.1%	1.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	729,143	711,779	720,354	795,308	-2.4%	1.2%	10.4%
НИЙТ ӨР ТӨЛБӨР	270,492	279,320	308,543	105,730	3.3%	10.5%	-65.7%
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,969	22,177	36,662	37,743	-7.5%	65.3%	2.9%
Нийт Өглөг	22,978	21,294	33,436	33,904	-7.3%	57.0%	1.4%
Ажилчидтай холбогдсон өглөг	51	59	60	62	15.8%	2.1%	2.2%
Зээлийн хүүгийн өглөг	4,574	4,719	4,916	-	3.2%	4.2%	100.0%
Байгууллагад төлөх өглөг	11,230	8,904	10,175	8,271	-20.7%	14.3%	-18.7%
Хувь хүмүүст төлөх өглөг	1,611	1,757	2,159	2,100	9.1%	22.8%	-2.7%
Татварын өглөг	2,216	2,752	5,659	5,965	24.2%	105.6%	5.4%
НДШ-ийн өглөг	1,127	508	1,427	1,817	-54.9%	180.8%	27.3%
Ноогдол ашгийн өглөг	-	68	21	-	0%	-69.5%	100.0%
Дансны өглөг	2,168	2,526	9,018	15,690	16.5%	256.9%	74.0%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	246,522	257,144	271,880	67,987	4.3%	5.7%	-75.0%
Урт хугацаат зээл	246,522	257,144	271,880	67,987	4.3%	5.7%	-75.0%
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	458,652	432,459	411,812	689,578	-5.7%	-4.8%	67.4%
Хуримтлагдсан үр дүн	(257,511)	(291,854)	(337,120)	(224,954)	13.3%	15.5%	-33.3%
Өмнөх үеийн үр дүн	(225,633)	(258,347)	(288,054)	(191,400)	14.5%	11.5%	-33.6%
Тайлант үеийн үр дүн	(31,879)	(33,507)	(49,067)	(33,554)	5.1%	46.4%	-31.6%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	729,143	711,779	720,354	795,308	-2.4%	1.2%	10.4%

Хавсралт - 7

Орлогын тайлангийн шинжилгээ

Үзүүлэлт	Тоон үзүүлэлт				Өсөлтийн хувь		
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
ОРЛОГЫН ДҮН	212,886	231,005	240,449	239,168	8.5%	4.1%	-0.5%

Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,947	194,629	191,655	204,359	10.0%	-1.5%	6.6%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,709	4,986	5,125	3,172	5.9%	2.8%	-38.1%
Түрээсийн орлого	-	-	-	13	0.0%	0.0%	0.0%
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	31,230	31,389	43,669	31,624	0.5%	39.1%	-27.6%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	229,141	257,500	279,204	272,710	12.4%	8.4%	-2.3%
Урсгал зардал	229,141	257,500	279,204	272,710	12.4%	8.4%	-2.3%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,605	46,786	54,021	53,758	2.6%	15.5%	-0.5%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,108	6,273	7,264	8,784	2.7%	15.8%	20.9%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,859	12,668	13,714	14,277	6.8%	8.3%	4.1%
Хангамж, бараа материалын зардал	110,666	117,829	126,582	128,832	6.5%	7.4%	1.8%
Нормативт зардал	144	201	244	209	39.6%	21.2%	-14.2%
Эд хогшил, урсгал засварын зардал	1,837	1,762	2,889	3,623	-4.1%	64.0%	25.4%
Томилолт, зочны зардал	109	232	2	8	113.3%	-99.3%	400.6%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,736	20,236	22,341	17,224	20.9%	10.4%	-22.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	31,566	46,718	47,253	45,369	48.0%	1.1%	-4.0%
Хүүний зардал	4,204	4,564	4,710	-	8.6%	3.2%	-100.0%
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	8,408	9,129	9,419	-	8.6%	3.2%	-100.0%
Урсгал шилжүүлэг	349	289	265	644	-17.3%	-8.2%	142.9%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(16,255)	(26,496)	(38,754)	(33,542)	63.0%	46.3%	-13.4%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,623	7,012	10,312	12	-55.1%	47.1%	-99.9%
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	946	811	128	12	-14.3%	-84.2%	-90.9%
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	14,677	6,201	10,184	0	-57.8%	64.2%	-100.0%
Татвар төлөхийн өмнөх ашиг	(32,524)	(33,961)	(49,300)	(33,588)	4.4%	45.2%	-31.9%
Орлогын татварын зардал	646	454	233	35	-29.7%	-48.7%	-85.1%
Татварын дараах цэвэр ашиг	(31,879)	(33,507)	(49,067)	(33,554)	5.1%	46.4%	-31.6%

Хавсралт 8.

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДЫН 2019-2021 ОНЫ ОРЛОГО ЗАРДАЛ

№	ОНӨААТҮГ-ын нэрс	/сая.төг/					
		Нийт орлого			Нийт зардал		
		2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл
1	ОСНААУГ	91,378.6	94,597.1	98,962.60	102,441.54	106,460.72	107,742.34
2	УСУГ	66,138.4	66,112.8	69,765.75	83,002.28	93,302.14	84,265.29
3	Зорчигч тээврийн нэгтгэл	37,361.3	31,011.6	33,764.99	37,781.16	36,487.90	39,093.20
4	УБЗЗАГ	18,359.7	10,459.2	13,968.20	18,345.08	12,811.86	13,955.08
5	Хот тохижилтын газар	12,841.8	19,571.4	16,815.25	14,082.77	19,916.22	18,246.05
6	Зорчигч тээвэр гурав	11,813.7	23,187.3	16,869.95	13,294.24	23,164.15	15,422.40
7	Өсвөр үе хүнс	6,557.8	2,213.5	1,772.91	6,465.23	2,421.83	1,918.41
8	Хүнс хангамж төв	5,273.8	2,133.5	1,690.64	5,263.01	2,317.44	1,924.73
9	Багачууд хүнс	4,084.8	1,616.5	1,160.44	4,039.60	1,789.34	1,314.76
10	Асгат	2,873.9	992.8	745.90	2,839.00	1,228.52	946.87
11	ГУББГ	3,785.9	5,418.8	4,370.13	7,622.16	9,279.27	8,212.92
12	Хөрөнгө оруулалтын газар	3,017.4	3,767.2	3,794.78	2,919.21	4,128.82	3276.73427

13	ХИХУГ	2,951.9	3,983.4	4,666.70	3,541.99	3,577.87	5,041.48
14	ХТСИ	1,058.3	2,235.4	3,018.70	1,235.22	2,171.26	2,750.62
15	Гэрлэх ёслолын ордон	1,139.0	551.1	160.60	1,066.45	907.37	560.44
Нийт дүн		268,636.35	267,851.60	271,527.54	303,938.94	319,964.72	304,671.30

Хавсралт 9.

Цахим хуудсаар мэдээллийн ил тод байдлыг хангасан байгууллагууд

№	Байгууллагын нэр	Цахим хуудастай эсэх	Үйл ажиллагааны тайлангаа мэдээлсэн эсэх	Санхүүгийн тайлангаа байршуулсан эсэх
1	БГД Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
2	БЗД НҮГ-1	Үгүй	Үгүй	Үгүй
3	БЗД НҮГ-2	Үгүй	Үгүй	Үгүй
4	БЗД НҮГ-3	Үгүй	Үгүй	Үгүй
5	БЗД НҮГ-4	Үгүй	Үгүй	Үгүй
6	ГУББГ ОНӨААТҮГ	Тийм	Үгүй	Үгүй
7	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
8	Зорчигч тээвэр нэгтгэл ОНӨААТҮГ	Тийм	Тийм	Тийм
9	Налайх АЗЗА	Үгүй	Үгүй	Үгүй
10	Налайх дулаан ТӨХК	Тийм	Тийм	Тийм
11	НД Гэрэлтүүлэг Чимэглэлийн алба ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
12	НД Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
13	НД Цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
14	НД Чандмань Налайх ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
15	НОСК ХК	Тийм	Тийм	Тийм
16	Олон улсын логистик худалдааны төв	Тийм	Тийм	Тийм
17	ОСНААУГ ОНӨААТҮГ	Тийм	Тийм	Тийм
18	СБД Дэвшил	Үгүй	Үгүй	Үгүй
19	СБД Сүхбаатар дэвшил менежмент ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
20	СБД Тохижилт			
21	СХД Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
22	СХД Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
23	УБЗЗАГ ОНӨААТҮГ	Тийм	Тийм	Тийм
24	Улаанбаатар хотын хөгжлийн корпорац	Тийм	Тийм	Тийм
25	Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент	Тийм	Тийм	Тийм
26	УСУГ ОНӨААТҮГ	Тийм	Тийм	Тийм
27	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ	Тийм	Тийм	Тийм
28	Хот тохижилт ОНӨААТҮГ	Тийм	Тийм	Тийм
29	ХУД ТҮТ	Тийм	Тийм	Тийм
30	ХУД Хан-Уул Агро ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
31	ЧД Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв ОНӨААТҮГ	Үгүй	Үгүй	Үгүй
32	ЧД ТҮК ХХК	Үгүй	Үгүй	Үгүй

**Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2019-2020 онд шилэн
дансанд мэдээлсэн байдал**

Нэр	Байршуулбал зохих мэдээллийн тоо	Байршуулсан мэдээллийн тоо	Мэдээлсэн байдал /хувиар/
УБЗЗАГ	795	202	25.4
СБ Дэвшил менежмент	28	9	32.1
ОУХ Логистик	434	190	43.8
Геодизи УББГ	357	175	49.0
СБ Дэвшил	490	279	56.9
БЗД НҮГ 2	392	248	63.3
Зорчигч тээвэр нэгтгэл	398	252	63.3
УБХО Менежмент	339	218	64.3
Налайх Гэрэлтүүлэг	319	221	69.3
Налайх АЗЗА	381	277	72.7
БЗД НҮГ 1	427	316	74.0
УБХ Корпорац	238	183	76.9
Налайх Чандмань	434	335	77.2
СХД Төхижилт	394	305	77.4
БГД Шинэ өргөө	449	348	77.5
Гэрлэх ёслолын ордон	322	259	80.4
СХД Тээвэрлэлт	364	295	81.0
ХУД Агро	374	308	82.4
Налайх тохижилт	256	214	83.6
ЖДҮ дэмжих төв ЧД	207	179	86.5
Налайх Цэцэрлэгжүүлэлт	342	302	88.3
Нийслэлийн орон сууц корпорац ХК	504	448	88.9
ҮЦХүрээлэн	447	408	91.3
БЗД НҮГ 3	390	368	94.4
БЗД НҮГ 4	399	377	94.5
ХУД тохижилт	319	304	95.3
Хот тохижилт	1080	1041	96.4
ОСНААУГ	11885	11461	96.4
УСУГ	1697	1666	98.2